



ОХУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох

Монгол улсын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдэд зориулсан
цогц гарын авлага

2020 он

Published by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Хэвлэлт

Хэвлэсэн

Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

Хаяг

Бонн, Эшборн хот, ХБНГУ
Фредих-Элберт-Аллэ 32-36
Д-53113 Бонн, ХБНГУ
Утас +49 228 4460-0

Даг-Хаммарскуолд-Бер 1-5

Д-65760 Эшборн, ХБНГУ

Утас +49 6196 79-0

Цахим хаяг info@giz.de

Цахим хуудас www.giz.de

Төслийн нэр

Ази дахь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих (SRECA)

ТаЮуан Дипломат Байр

14 Лиангмае Өмнөд Гудамж, Чаояанг Дүүрэг

10600 Бээжин, БНХАУ

Утас +86-10-8532-1857

Цахим хаяг sreca@giz.de

Цахим хуудас www.connecting-asia@giz.de / www.giz.de/en/worldwide/34101.html

Зохиогчид/Боловсруулсан

Д.Адьяасүрэн, А.Доржпалам, Н.Отгонсайхан

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим-МҮХАҮТ

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль-ХҮИС

Улаанбаатар 17011, Хан-Уул дүүрэг, М.Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр, 305 тоот

Утас: + (976) 91919396, + (976) 77277070

Цахим хаяг adyasuren@mongolchamber.mn

Цахим хуудас www.mongolchamber.mn

Хянасан

С. Золзаяа, GIZ SRECA

Флориан Мисс, GIZ SRECA

Зураг

GIZ

Агуулгын хариуцлагаас татгалзах тухай

Энэхүү гарын авлагад зохиогчдын зүгээс илэрхийлсэн үзэл бодол болон саналд байгууллагын саналыг тусгаж, илэрхийлээгүй болно. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) нэрийн өмнөөс/даалгавраар GIZ нь хэрэгжүүлэгч агентлагийн хувьд гарын авлагын агуулгыг хариуцна.

Агуулга

Агуулга	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
1. ОХУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
1.1. ОХУ-ЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
1.2. ОХУ-ЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОГ	8
1.2.1 ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭ	8
1.2.1. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ...	9
1.3. МОНГОЛ УЛСЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, НИЙЛҮҮЛЭЛТ	10
1.3.1 ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ	10
1.3.2. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ	12
2. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БОЛОМЖ, ЗОХИЦУУЛАЛТ	12
2.1. МОНГОЛ УЛСААС ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙН ЭКСПОРТЫН ТАЛААР БАРИМТЛАЖ БҮЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ	12
2.2. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОХ ЗОХИЦУУЛАЛТ	15
2.2.1. ОХУ-ЫН ГААЛИЙН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ	15
2.2.2. ОХУ-ЫН ТАРИФЫН БУС ЗОХИЦУУЛАЛТ	17
3. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БЭЛТГЭЛ АЖИЛ	18
3.1. МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙЛГЭХ	18
3.1.1. МАЛ АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ СОНИРХОЛ БҮХИЙ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МОНГОЛ УЛСЫН ТАЛААС ХИЙХ ХЯНАН МАГАДЛАГАА	19
3.1.2. ОХУ/ЕАЭЗХ-НЫ ОРНУУДЫН ЗАХ ЗЭЭЛД МАЛ АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ СОНИРХОЛ БҮХИЙ ГУРАВДАГЧ ОРНЫ ҮЙЛДВЭР АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ХЯНАН МАГАДЛАГАА	20
3.1.3. ОХУ/ЕАЭЗХ-НЫ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС МАЛ ТӨХӨӨРӨХ, МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖИД ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙХ УДИРДАМЖ	22
3.1.4. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ	35
3.2. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ	38
3.3. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	40
3.3.1. ТӨЛБӨР ТООЦОО	40

3.3.2. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	41
3.4. САВ БАГЛАА БООДОЛ, ШОШГО.....	42
3.4.1. САВ, БАГЛАА БООДОЛ, ШОШГОЛОЛТОД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	42
3.4.2. САВ БАГЛАА БООДЛЫН СТАНДАРТ, ТУСГАЙ ШААРДЛАГА	43
3.4.3 ШОШГО, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, КОДЧЛОЛ.....	46
4. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ЭКСПОРТЛОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, ҮЙЛ ЯВЦ.....	47
4.1. ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ	49
4.1.1. МАЛ ЭМНЭЛЭГ, ХОРИО ЦЭЭРИЙН ГЭРЧИЛГЭЭ	49
4.1.2. ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТОЛЖ ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ ГЭРЧИЛГЭЭ (ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ)	50
4.1.3. ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ	51
4.1.4. ГАРАЛ ҮҮСЛИЙН УЛ МӨРИЙГ МӨШГИХ (TRACEABILITY).....	51
4.2. ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ	51
5. БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ АЖ АХУЙН НЭГЖИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	52
5.1. ЗАХ ЗЭЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР	52
5.2. ОХУ-ЫН ГААЛЬ ДЭЭР ГАРДАГ ЗАРИМ АСУУДАЛ БУСАД ЗҮЙЛИЙН ТАЛААР	54
6. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД	55
6.1. МОНГОЛЫН ТАЛААС БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	55
6.2. ОХУ-ЫН ТАЛААС ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА, БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ	56
7. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ОРОЛЦДОГ БАЙГУУЛЛАГА	57
8. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ПРОГНОЗ	58
9. ХАВСРАЛТУУД	59

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. ОХУ-д худалдаалагдаж буй махны бөөний болон жижиглэнгийн дундаж үнэ, 2019 оны 9 дүгээр сар.....	8
Хүснэгт 2. ОХУ-ын боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8
Хүснэгт 3. Монгол Улсын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний экспорт, тонн	12
Хүснэгт 4. Махны экспортод хамаарах Монгол улсын бодлогын бичиг баримтын гол заалт, эрх зүйн зохицуулалт	13
Хүснэгт 5. ОХУ-ын боловсруулсан махны импортын гаалийн тариф.....	16
Хүснэгт 6. ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлоход дагаж мөрдөх шаардлагатай тарифын бус зохицуулалтын жагсаалт	17
Хүснэгт 7. Үйлдвэрийн ариутгалыг тодорхойлох арга.....	35
Хүснэгт 8. Мэдрэхүйн болон физик-химийн үзүүлэлт.....	36
Хүснэгт 9. ТР ТС 021/2011 “Хүнсний аюулгүй байдлын тухай” техникийн зохицуулалт	37
Хүснэгт 10. Гаалийн холбооны техникийн горим. ТР ТС 034/2013, №№-1-2.....	37
Хүснэгт 11. Гэрээний нөхцөл, анхаарах зарим асуудал.....	38
Хүснэгт 12. Шил, шаазан, фаянс, эдгээрээс гаргаж авсан сав болон керамик эдлэлээс ялгарах хар туглага, кадмийн эрүүл ахуйн норматив үзүүлэлт.....	45

Хүснэгт 13. Сав болон таг үйлдвэрлэхэд ашигладаг метал ба хайлшнаас гаргах бодисын аюулгүй байдал эрүүл ахуй, эрүүл ахуйн норматив үзүүлэлтүүд.....	45
Хүснэгт 14. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дараалал /20 тонн/	47
Хүснэгт 15. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах зарцуулах цаг хугацаа, зардал.....	47

Зургийн жагсаалт

Зураг 1. ОХУ-ын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импорт, түнш орноор, мян.тонн	9
Зураг 2. ОХУ-ын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импортод түнш орнуудын эзлэх хувийн жин, %.....	10
Зураг 3. Монгол Улсын үхрийн мах үйлдвэрлэх нөхцөл байдал	11
Зураг 4. Монгол Улсын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 1989-2018 он.....	11
Зураг 5. ОХУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц	18
Зураг 6. ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дарааллын цаг хугацаа, зардлын диаграмм	48
Зураг 7. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дарааллын зураглал.....	48
Зураг 8. ОХУ-д экспортлох боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний прогноз	58

Хайрцгийн жагсаалт

Хайрцаг 1. Монгол Улсын мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил	19
Хайрцаг 2. Монголын мах боловсруулах үйлдвэрүүдэд Гаалийн холбооны орнуудын мэргэжилтнүүдийн хамтарсан шалгалтаар илэрсэн нийтлэг дутагдал	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУЗГ	Монгол улсын засгийн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
ММХ	Монголын махны холбоо
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтаны эрүүл мэндийн байгууллага
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ЕАЭЗХ	Евразийн эдийн засгийн холбоо
Россельхознадзор	ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын алба
ГМО	Генийн өөрчлөлттэй организм
БАД	Биологийн идэвхтэй нэмэлт
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
НАССР	Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоо
ISO	Олон улсын Стандарчлалын байгууллага
GMP	Үйлдвэрлэлийн зохистой дадал
GHP	Эрүүл ахуйн зохистой дадал
ХЕС	Хөнгөлөлтийн ерөнхий систем
ҮНТН	Үндэсний нэн тааламжтай нөхцөл

1. ОХУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. ОХУ-ЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрлэл. ОХУ-д махны үйлдвэрлэл 2001-2018 онд тасралтгүй нэмэгдэж¹, 2018 онд мах нядалгааны жингээр 10.6 сая тонн байсан нь өмнөх онтой харьцуулахад 3.0% (0.3 сая тонн)-аар өсчээ. Энэ хугацаанд гахай, шувуу, хонины махны үйлдвэрлэл нэмэгдсэн бол үхрийн махны үйлдвэрлэл буурсан. 2018 онд нийт махны үйлдвэрлэлд шувууны мах 46.9%, гахайн мах 35.2%, үхрийн мах 15.1%, хонины мах 1.9%, ямааны мах 0.2%, бусад мах үлдсэн хувийг эзэлжээ. 2019 онд 10 820.9 мян. тонн болж өмнөх оноос 1.8 хувиар өсөх төлөвтэй байна².

Импорт. ОХУ-ын махны импорт 2001-2008 оныг хүртэл өссөн бол 2009-2019 онд тогтмол буурчээ. Тухайлбал, 2008 онд махны импорт 3 618.0 мян. тонн байсан бол 10 жилийн хугацаанд 5 дахин буурч 2018 онд 756.1 мян. тонн, 2019 онд 738.2 мян. тонн болох прогноз хийжээ. 2018 оны импортын бүтцийг авч үзвэл, нийт импортод үхрийн мах 45.6%, тахианы мах 28.7%, үхрийн дайвар мах 11.2%, гахайн мах 8.1%, гахайн өөх 2.7%, адууны мах 1.5%, цацагт хяруулын мах 0.5%, хонины мах 0.4% бусад мах үлдсэн хувийг эзэлжээ.

Экспорт. ОХУ-ын махны экспорт 2001-2008 оныг хүртэл маш бага байсан бол 2009-2018 онд тогтмол өсөлттэй байна. Тухайлбал, 2009 онд махны экспорт 9.7 мян.тонн байсан бол 2018 онд 289.7 мян. тонн болж, 9 жилийн хугацаанд 30 дахин өсчээ. 2018 оны экспортын бүтцийг авч үзвэл, нийт экспортод тахианы мах 62%, гахайн дайвар бүтээгдэхүүн 16.8%, гахайн мах 11.6%, хонины мах 4.3%, үхрийн мах 1.5%, үхрийн дайвар бүтээгдэхүүн 1.2% бусад мах үлдсэн хувийг эзэлжээ.

Зах зээл. ОХУ-ын Агробизнес төвийн тооцоогоор ОХУ-ын махны зах зээл 2001-2013 онд тогтвортой өргөжих хандлагатай байсан бол 2014-2015 онд үйлдвэрлэл нэмэгдсэн ч импортын уналтаас бага зэрэг бууралт ажиглагдсан³. 2016-2019 онд зах зээлийн өргөжилт үргэлжилж, 2018 онд 11 095.8 мян.тонн, 2019 онд 11 273.5 мян.тонн хүрнэ гэж таамаглаж байв.

Хэрэглээ хангамж. ОХУ-ын нэг хүн амд ногдох махны хэрэглээ 2018 онд 75.6 кг болж, тус улсын Агробизнес төвийн тооцоогоор сүүлийн 10 жилд 9.1%, 15 жилд 42.2%-аар өсчээ. 2019 онд 76.9 кг болох төлөвтэй байв. Дотоодын үйлдвэрлэлээр махны хэрэгцээгээ хэрхэн хангаж байгаа байдлыг авч үзэхэд, 2005 онд хамгийн доод төвшинд буюу 60.7% байсан бол 2006 оноос тогтвортой сайжирч 2014 онд 84.7% болсон нь махны хувьд хүнсний хараат⁴ байдлаас гарч чадсан. Түүнээс хойш энэ үзүүлэлт сайжирч 2018 онд 95.8%, 2019 онд 96% болох хүлээлттэй байсан. Хүнсний хараат байдлын үзүүлэлт сайжрахад тодорхой хугацаанд үе шаттай авч хэрэгжүүлсэн дараах үйл ажиллагаа нөлөөлсөн. Үүнд:

- импортын махны квотын хэмжээг үе шаттайгаар бууруулсан;
- АНУ-аас импортлох шувууны маханд хязгаарлалт хийсэн;
- бусад орны ялангуяа Европын холбоо, Канад, АНУ-аас импортлох маханд 2014 оноос, Бразилийн импортлох гахайн маханд 2018 оноос хязгаарлалт хийсэн;

¹ Сүүлийн 5 жилийн хугацаанд 24.7%, 10 жилийн хугацаанд 69.3%, 15 жилийн хугацаанд 112.9% -иар өссөн.

² Экспертно-Аналитический центр агробизнеса <https://ab-centre.ru/>

³ 2013 онд 10 885.8 мян.тонн, 2015 онд 10 603,8 мян.тонн

⁴ Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтээр хараат байдлын доод түвшин 85% байдаг.

- импортын бууралтыг дотоодын махны үйлдвэрлэлээр бүрэн нөхөх гэх мэт.

Үнэ. ОХУ-ын үндэсний статистикийн мэдээллээс үзэхэд, 2019 оны 9 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад гахайны махны бөөний (үйлдвэрлэгчийн) үнэ 18.5%, үхрийнх 0.1% буурсан бол шувууны махны үнэ 8.3%, хониных 5.1% өсчээ. 2017-2019 оны байдлаар авч үзвэл: гахайны махны үнэ 6.6% -аар буурч, үхрийн махны үнэ 0.1%, хониных 65.8%, шувууных 15.3%-аар өссөн байна⁵. Хүснэгт 1-д төрөл бүрийн махны бөөний болон жижиглэнгийн дундаж үнийг 2019 оны 9 дүгээр сарын байдлаар харуулав.

Хүснэгт 1. ОХУ-д худалдаалагдаж буй махны бөөний болон жижиглэнгийн дундаж үнэ, 2019 оны 9 дүгээр сар

2019 оны 9 сар	Хонь	Үхэр	Шувуу	Гахай
Бөөний (үйлдвэрлэгчийн) үнэ, рубль	282.5	230.2	143.7	106.6
Жижиглэнгийн үнэ, рубль	420.4	343.1	270.6	146.8

Тайлбар: Монголбанкны ханшаар (2019.09.30) 1 рубль 41.26 төгрөгтэй тэнцэж байв.

1.2. ОХУ-ЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОГ

1.2.1 ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭ

Сүүлийн жилийн статистик мэдээллээс харахад ОХУ жилд дунджаар нядалгааны жингээр 1600 орчим мян.тн үхрийн мах үйлдвэрлэж байгаа нь шувуу, гахайны махны дараа орж байна. 2018 онд 1645 мян. тонн үхрийн мах үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1.9%-аар (31.5 мян. тн) өсч нийт махны үйлдвэрлэлийн 15.1% эзэлжээ.

ОХУ жилд дунджаар 600 -750 орчим сая стандарт лааз лаазалсан мах үйлдвэрлэдэг, сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдвэрлэл тогтмол буурч 2018 онд 605 сая стандарт лааз болсон нь өмнөх онтой харьцуулахад 37 сая, 2014 онтой харьцуулахад 141 сая стандарт лаазаар буурсан.

Хүснэгт 2. ОХУ-ын боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Нэр төрөл	2014	2015	2016	2017	2018/2019
1	Үхрийн мах, сая.тн	1.654	1.649	1.619	1.614	1.645
2	Лаазалсан мах, сая стандарт лааз (350 гр)	746	649	643	642	605
3	Лаазалсан махны (350 гр) жижиглэнгийн үнэ, рубль	83.9	112.5	119.6	122.9	126.1/135.4

Эх сурвалж: Росстат болон Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ <http://www.fao.org/faostat/en/#data/QL>

ОХУ-ын нэг хүн амд ногдох махны хэрэглээ 2018 онд 75.6 кг байснаас үхрийн мах-15 кг (шувууны мах -35 кг, гахайны мах-25 кг, бусад мах 0.6 кг)-ыг нь бүрдүүлж байна. ОХУ-ын сүүлийн 3 жилийн статистикээс харахад жилд дундажаар 2100 орчим мян.тонн үхрийн мах хэрэглэж байна, үүнээс 78-80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангажээ.

⁵ Сүүлийн 5 жилээр (2014.09) авч үзвэл: гахайны махны бөөний үнэ 17,0% буурсан, үхрийн махных 34,9%, шувууных 15,0%, хониных 32,6% өссөн.

ОХУ-д сүүлийн жилүүдэд лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ буурч байгаа бөгөөд дараах хүчин зүйл нөлөөлсөн гэж үзжээ. Үүнд:

- ✓ *Технологийн.* Логистикийн зардлыг бууруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатай болсон.
- ✓ *Нийгмийн.* Үндсэн 2 шалтгаантай байсан. Нэгд, лаазалсан махны үнэ нэмэгдэж байгаа, 2017-2019 онд үнэ 10-25% өсчээ. Хоёрт, хэрэглэгчид эрүүл хооллох хандлагатай болсон, лаазалсан бүтээгдэхүүнийг консервант агуулсан, хямд түүхий эдээр үйлдвэрлэдэг гэж үздэг учраас худалдан авалт буурсан.
- ✓ *Улс төрийн.* Импортыг орлох зорилгоор гааль, татварын зохицуулалтад өөрчлөлт оруулсан нь нэг талаас дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахад чиглэсэн ч нөгөө талаас бараа бүтээгдэхүүний чанарыг бууруулахад хүргэсэн.

1.2.1. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ


ОХУ нь 2018 оны байдлаар 20 орноос 18.3 мян. тонн боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг (БТКУС-ийн 1602: Мах, дайвар мах эсвэл цусаар хийж бэлтгэсэн эсвэл нөөшилсөн бусад бүтээгдэхүүн) 77.8 сая доллараар худалдан авсан ⁶ нь дэлхийн боловсруулсан махны нийт импортын 0.5 % болж⁷, 29 дүгээр байр эзэлжээ.

ОХУ-ын 2018 онд импортоор авсан нийт боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний 38 хувийг үхрийн махан бүтээгдэхүүн (БТКУС-ийн 160250: - үхрийн махан) эзэлж байгаа бөгөөд 6.9 мян.тонныг 27 сая доллараар (дундажаар 1 кг нь 3.9 доллар) худалдан авчээ.

Монгол Улс нь 2018 онд ОХУ-ын нийт боловсруулсан махны импортод 8 дугаар байр, боловсруулсан үхрийн махны импортод Беларусийн дараа хоёрдугаар байр эзэлсэн.

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсаас жилд 26-310 тонн боловсруулсан мах импортоор авсан бөгөөд бусад түнш орнуудтай харьцуулсан мэдээллийг Зураг 1-ээс харна уу.

Зураг 1. ОХУ-ын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импорт, түнш орноор, мян.тонн



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв <https://www.trademap.org/Index.aspx>


⁶ 1 тонн боловсруулсан махны үнэ 4257 доллар

⁷ Япон-19.6% (I), Англи -15.8% (II), Герман -7.1% (III), АНУ-5.6% (IV), Нидерланд-5% (V)

ОХУ-ын нийт дулааны аргаар боловсруулсан махны импортын зах зээлд сүүлийн 5 жилд Беларусь I байр (45-70%), Итали II байр (3.6-8%) эзэлж байгаа бөгөөд Зураг 2-оос дэлгэрэнгүй мэдээллийг харна уу. Монгол Улсаас 2017 онд 310 тонн боловсруулсан мах импортолж, нийт импортын 1.8% болсон нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр тоо байжээ.

ОХУ нь 2018 онд Монгол Улсаас 264 тонн (нийт импортын 1.4%) боловсруулсан махыг дундажаар килограммыг нь 2.7 доллараар импортолсон.

Зураг 2. ОХУ-ын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импортод түнш орнуудын эзлэх хувийн жин, %



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв <https://www.trademap.org/Index.aspx>

2018 онд боловсруулсан үхрийн махыг ОХУ нь Беларусь (6.3 мян.тонн буюу 91%, 1кг-3.8\$), Монгол Улс (238 мян.тонн буюу 3.4%, 1кг-2.7\$), Казакстан (163 мян.тонн буюу 2.4%, 1кг-2.4\$), Бельги (1кг-5.9\$), Итали (1 кг-21.3\$), Армен (1 кг-3.4\$), Серб (1 кг-5.6\$), Испани (1 кг-12.5\$), Швейцарис(1 кг-24\$) импортоор авсан.

1.3. МОНГОЛ УЛСЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, НИЙЛҮҮЛЭЛТ

1.3.1 ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Экспортлох махны нөөц нь малын тоо, түүний өсөлт, үйлдвэрлэл, боловсруулалт, хүн амын хэрэглээтэй шууд холбоотой. Монгол Улсын нийт үхрийн тоо жил бүр өсч⁸ 2018 онд 4390.9 мян. толгой хүрсэн нь 2017 онтой харьцуулахад 2.4 мян.толгойгоор нэмэгдсэн.

2018 онд 126.6 мян. тонн үхрийн мах бэлтгэснээс 4.3 хувь буюу 5.5 мян. тонныг нь үйлдвэрийн аргаар боловсруулжээ.

⁸ 2014 онд -3 413 851, 2015 онд- 3 780 402, 2016 онд - 4 080 936


Зураг 3. Монгол Улсын үхрийн мах үйлдвэрлэх нөхцөл байдал



Эх сурвалж: МУ-ын статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ХХААХҮЯ

Монгол Улс 1989 онд 1.7 мян. тонн нөөжилсөн мах, 5.8 мян.тонн хиаман төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 1995 он хүртэл тогтмол буурч нөөш 0.43 мян.тонн, хиаман бүтээгдэхүүн 0.64 мян.тонн болжээ. 2018 онд 5.69 мян. тонн хиаман бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь бараг 1989 оны түвшинд дөхөж очжээ.

Зураг 4. Монгол Улсын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 1989-2018 он



Эх сурвалж: МУ-ын статистикийн мэдээ

Монгол улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр⁹ 2019 оны байдлаар, 18 аймгийн 23 сум, нийслэлийн 4 дүүрэгт үйлдвэрийн аргаар мал төхөөрөх үйл ажиллагаа явуулж байгаа 88 үйлдвэр байдаг бөгөөд эдгээрийн нийт хүчин чадал нь жилд 9.7 сая бог, 1.9 сая бод, нийт 11.6 сая толгой мал төхөөрөх боломжтой юм байна.

Дээрхи аж ахуйн нэгжүүдээс мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй 70 үйлдвэр байгаа үүнээс ОХУ-д үхрийн хөргөсөн, хөлдөөсөн мах экспортлох эрх авсан 30, дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлох эрх авсан 9 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

⁹ <http://home.inspection.gov.mn/news/248/single/2009>

1.3.2. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Монгол Улс 2001 оноос хойш ОХУ, БНХАУ, БНАСУ, Индонез, Иран, Япон, БНСУ, Нидерланд зэрэг орнуудад боловсруулсан мах экспортолсон. 2016 оноос хойш зөвхөн ОХУ, БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд дийлэнх буюу 80-99 хувь нь БНХАУ-д ногдож байна.

2018 онд Монгол Улс 29.2 мян.тонн боловсруулсан мах (ОХУ-д 234 тонн) экспортолсноос 9.5 мян. тонн нь үхрийн махан бүтээгдэхүүн, үүнээс 185 тонныг ОХУ-д гаргасан нь нийт боловсруулсан үхрийн махны экспортын 2 орчим хувийг эзэлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах Хүснэгтээс харна уу.

Хүснэгт 3. Монгол Улсын дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний экспорт, тонн

	2014		2015		2016		2017		2018	
	Нийт	Үхрийн махан	Нийт	Үхрийн махан	Нийт	Үхрийн махан	Нийт	Үхрийн махан	Нийт	Үхрийн махан
Нийт	23	23	170	154	437	359	2,831	1,222	29,222	9,501
БНХАУ	0	0	0	0	354	279	2,536	970	28,989	9,316
ОХУ	23	23	141	141	83	79	294	252	234	185

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв <https://www.trademap.org/Index.aspx>

ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн улсын албаны /Россельхознадзор/ зөвшөөрөлтэй боловсруулсан үхрийн мах экспортлох 10 аж ахуйн нэгж¹⁰ байгаа бөгөөд одоогийн байдлаар 9 нь ямар нэг нэмэлт хориг, хязгаарлалтгүйгээр экспорт хийх боломжтой. Эдгээр аж ахуйн нэгжийн 8 нь Улаанбаатарт, 1 нь Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатарт байршилтай 1 аж ахуйн нэгжийн экспортыг түр хугацаагаар зогсоосон.

2. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БОЛОМЖ, ЗОХИЦУУЛАЛТ

2.1. МОНГОЛ УЛСААС ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙН ЭКСПОРТЫН ТАЛААР БАРИМТЛАЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын нийт малын тоо 2018 оны байдлаар 66.5 сая болж, 2014 онтой харьцуулахад 28 хувиар нэмэгджээ. Малын тоо өсч байгаа нь сайн хэрэг боловч бэлчээрийн даац хэтрэх, хүлэмжийн хий ихсэх, өвс тэжээлийн нөөц хүрэлцэхгүй байх, малын өвчин дэлгэрэх зэрэг сөрөг үр дагавар, эрсдэл үүсгэх магадлал өндөр гэдгийг судлаачид хэлдэг. Тиймээс мах экспортлох оновчтой цогц (эрүүл ахуй, хорио цээр, лаборатори, сертификат, нийлүүлэлтийн сүлжээ гэх мэт) бодлого хэрэгжүүлэх нь дээрх сөрөг үр дагаврыг бууруулахын зэрэгцээ экспортын орлогыг нэмэгдүүлэх нэг чухал гарц байж болох талтай.

¹⁰<http://www.fsvps.ru/fsvps/importExport/mongolia/enterprises.html?product=5&productType=1>/2019.12.19/

Монгол улсад экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт, дунд, богино хугацааны төрийн бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжиж байгаа бөгөөд эдгээрийн нэр, хэрэгжих хугацаа, махны экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн гол үйл ажиллагаа болон махны экспортод хамаарах хуулиуд, тэдгээрийг голлох заалтуудыг нэгтгэн Хүснэгт 4-т харуулав. Мах экспортлогчид эдгээр бодлогын бичиг баримтад заасан боломжуудыг ашиглах, түүнчлэн зорилтыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, мөн эрхзүйн зохицуулалтын хүрээнд ямар боломж, хязгаарлалт байгаа эсэхийг сайтар судлах шаардлагатай.

Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журамд үндэслэн жил бүр Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр, төрөл тоо, хэмжээг баталдаг. Уг тушаалаар үхрийн махыг 2019 онд 29.9 мян.тонн экспортлохоор тусгасан нь өмнөх онтой харьцуулахад 2.0 мян. тонноор нэмэгдсэн, 2017 онтой харьцуулахад 8.1 мян. тонноор буурчээ.

Хүснэгт 4. Махны экспортод хамаарах Монгол улсын бодлогын бичиг баримтын гол заалт, эрх зүйн зохицуулалт

Бичиг баримт нэр	Хэрэгжих хугацаа	Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого
А. Төрийн бодлого, хөтөлбөр		
Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 ¹¹	2016-2030	Махыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. Үүнд: I үе шат /2016-2020 он/- 30% II үе шат /2021-2025 он/ - 50% III үе шат /2025-2030 он/-70%
Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого ¹²	2015-2025	2.1.1. ...махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх 6.2.2.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, экспортыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах;
Төрөөс малчдын талаар баримтлах бодлого ¹³	2009-2020	Үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах: 2014 он – 16.8 мян.тонн 2020 он – 100 мян.тонн 2025 он – 200 мян.тонн
Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ¹⁴	2016-2020	2.2.Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ. 2.27.Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний

¹¹ <https://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>

¹² <https://www.legalinfo.mn/annex/details/6968?lawid=11485>

¹³ <https://www.legalinfo.mn/annex/details/3305?lawid=6505>

¹⁴ <https://www.legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>

		экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мян. тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. 2.32.Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
Монгол экспорт хөтөлбөр ¹⁵	2018-2022	Үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж
Мах, сүүний анхдугаар аян ¹⁶	2017-2020	2020 онд: Махны экспортын хэмжээ - 100 мян. тн Махны экспортоос олох орлого – 63 сая доллар
В. Хууль эрхзүйн акт		
Мал амьтны эрүүл мэндийн тухай	2017.12.08	1.1.мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих...
Малын генетик нөөцийн тухай	2017.12.14	1.1. ...мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтан /цаашид “мал” гэх/-ны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх ...
Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай	2011.06.02	1.1... хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих
Органик хүнсний тухай	2016.04.07	1.1. .хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлах...
Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй	2012.12.20	1.1. .хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах...

¹⁵ <https://www.legalinfo.mn/annex/showPrint/8719>

¹⁶ <http://mofa.gov.mn/exp/blog/10/249>

байдлыг хангах тухай		13.1.Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийнэ.
Хүнсний тухай ¹⁷	2012.12.20	6.7.Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно. 6.8.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.7-д заасны дагуу тогтоосон хэмжээнд багтаан Засгийн газраас баталсан журмын дагуу стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгоно. 11.1.Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортлоно.
Гаалийн тариф, гаалийн татварын тухай ¹⁸	2008.05.20	А.1. ...гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай ¹⁹	2015.07.09	11.2.Энэ хуулийн 7.1.3-т заасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах албан татварын хувь тэг /"0"/-тэй тэнцүү байна. 7.1.3.Монгол Улсаас экспортод гаргасан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ.

2.2. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОХ ЗОХИЦУУЛАЛТ

2.2.1. ОХУ-ЫН ГААЛИЙН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Дулааны аргаар боловсруулсан мах экспортлогчид ОХУ-ын зах зээлд нэвтрэх үед тарифын болон тарифын бус саад бэрхшээлтэй тулгарах учраас эдгээрийг урьдчилан тооцоолсон байх шаардлагатай юм. ОХУ нь Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-д²⁰ багтдаг тул тус

¹⁷ <https://www.legalinfo.mn/law/details/8912?lawid=8912>

¹⁸ <https://www.legalinfo.mn/law/details/208?lawid=208>

¹⁹ <https://www.legalinfo.mn/law/details/11227?lawid=11227>

²⁰ Евразийского экономического союза (ЕТТ ЕАЭС)- ОХУ, Казахстан, Беларусь улсуудын байгуулсан Гаалийн холбооны үндсэн дээр байгуулагдсан. 2017 оны байдлаар гишүүн орнуудын хоорондын бараа эргэлт 54,2 тэрбум доллар, гуравдагч орнуудтай хийсэн бараа эргэлт 633,8 тэрбум доллар буюу дотоодын бараа эргэлтээс 11,7 дахин илүү байна. Монгол улсын хувьд 2019 оны эхний 9 сард ЕАЭЗХ-ны орнуудтай хийсэн худалдааны хэмжээ өмнөх оны мөн үеэс 12.9% -иар өссөн. ЕАЭЗХ нь Вьетнам, Серб, Сингапур, Ирантай улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр, БНХАУ-тай Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээртэй бөгөөд Египет, Монгол, Тайланд, Энэтхэг улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна. Мөн Япон, Индонез, Өмнөд Солонгос зэрэг 50 гаруй улс ЕАЭЗХ-той хамтран ажиллах сонирхлоо илэрхийлээд байгаа юм байна. Дашрамд хэлэхэд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын 21 хот 1 сая хол давсан хүн амтай байгаа нь танай үйлдвэрийн бүтээгдэхүүний зах зээл ч байж болох юм.

холбооны гишүүд болох Казакстан, Беларусь, Армен, Киргизстантай²¹ импортын нэгдсэн гадаад тарифтай байдаг. Өөрөөр хэлбэл ЕАЭЗХ-ны гишүүн 5 орны импортын гаалийн тариф ижил гэж ойлгож болно²².

ОХУ (ЕАЭЗХ) нь тариф ногдуулах “хосолмол” системтэй. Импортын гаалийн татвар ногдуулахдаа гаалийн үнээс хувиар (ЕАЭЗХ-ны тарифын жагсаалтад үхрийн махан дайвар бүтээгдэхүүнд 20%) болон барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тооцох (ЕАЭЗХ-ны тарифын жагсаалтад үхрийн махан дайвар бүтээгдэхүүний 1 кг тутам 0.5 евро) хэлбэрийг хослуулан ашигладаг. Дараах хүснэгтэд Монгол Улсаас экспортолсон үхрийн боловсруулсан маханд ногдуулах импортын гаалийн тарифын жагсаалтыг харуулав.

Хүснэгт 5. ОХУ-ын боловсруулсан махны импортын гаалийн тариф

БТКУС код	Нэршил	Мөрдөж буй тариф	
		Нэн тааламжтай тариф (MFN)	Хөнгөлөлтэй тариф (GSP)
1602 50	– үхрийн махан:		
1602 50 100 0	– – дайвар бүтээгдэхүүн	– 20%, 1 кг тутамд 0.5 евро-с багагүй	15%
	– – бусад:		
1602 50 310	– – – солонина:		
1602 50 310 1	– – – – битүүмжилсэн савтай (лаазалсан)	– 20%, 1 кг тутамд 0.4 евро-с багагүй	15%
1602 50 310 9	– – – – бусад	– 20%, 1 кг тутамд 0.5 евро-с багагүй	
1602 50 950	– – – бусад:		
1602 50 950 1	– – – – битүүмжилсэн савтай (лаазалсан)	– 20%, 1 кг тутамд 0.25 евро-с багагүй	15%
1602 50 950 9	– – – – бусад	– 20%, 1 кг тутамд 0.5 евро-с багагүй	15%

Эх сурвалж: <http://www.eurasiancommission.org/ru/act/trade/catr/ett/Pages/default.aspx>

Дээрх хүснэгтээс харахад, ОХУ бүх төрлийн боловсруулсан махан бүтээгдэхүүнд импортын үнийн дүнгийн 20 хувийн нэн тааламжтай тариф (гаалийн үнээс хувиар) эсвэл боловсруулсан махны төрлөөс хамааран 1 кг тутам 0.25-0.5 еврогийн (барааны нэгжид мөнгөн илэрхийллээр) гаалийн татвар авах аж.

Харин Евразийн эдийн засгийн холбооны орнуудаас Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу нэн тааламжтай тарифаас 25 хувийн хөнгөлөлт эдлэх хөгжиж буй орны жагсаалтад Монгол улс багтдаг. Иймээс МУ-ын экспортлогч аж ахуйн нэгж нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МУХАҮТ)-аас “FORM A” гарал үүслийн гэрчилгээг авснаар ОХУ-ын 20 хувийн нэн тааламжтай тарифаас 25 хувийн хөнгөлөлт эдэлж 15 хувийн татвар төлөх юм.

²¹ Молдав улс ажиглагчийн статустай.

²² Uniform duty rate (customs duty) adopted by a common market or trading pact group to be assessed on imports from countries outside that market or group. Read more: <http://www.businessdictionary.com/definition/common-external-tariff-CET-or-CXT.html>

Гарал үүслийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа нь “Монгол улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох журам”-аар зохицуулагддаг²³.

ОХУ нь боловсруулсан үхрийн махны 90 гаруй хувийг Евразийн эдийн засгийн холбооны бусад гишүүн орнууд болох Беларусь, Казакстан, Арменаас импортоор авдаг бөгөөд эдгээр орны хувьд импортын гаалийн тариф “0” байгаа нь МУ-ын экспортын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

ОХУ нь үхрийн махны импортод “тарифтай тоо хэмжээний хязгаарлалт” тогтоодог бөгөөд 2020 онд үхрийн шинэ эсвэл хөргөсөн махны (HS0201) хувьд 40 мян. тонн, үхрийн хөлдүү мах (HS0202) 530 мян.тоннын квоттой байгаа ажээ.

2.2.2. ОХУ-ЫН ТАРИФЫН БУС ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ-ын зах зээлд боловсруулсан үхрийн мах импортлоход 33 төрлийн тарифын бус зохицуулалтыг хэрэглэдэг бөгөөд дараах хүснэгтэд нэгтгэн харуулав. Олон улсын худалдааны төвийн “Зах зээлд нэвтрэх”²⁴ хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

Хүснэгт 6. ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлоход дагаж мөрдөх шаардлагатай тарифын бус зохицуулалтын жагсаалт

A130 – Системийн хандлага 1 (өвчингүй бүс нутаг, үйлдвэрлэл, стандарт)
A140 – Тодорхой бүтээгдэхүүн импортлох зөвшөөрөл (SPS) 1
A150 – Импортлогчийн (компани) зөвшөөрөл (SPS) 2
A210 – Тодорхой (микробиологийн бус) бодисын үлдэгдэл, бохирдлын хязгаар 2
A220 – Тодорхой бодисын хязгаарлалт 3
A310 – Хаяг шошгоны шаардлага 3
A320 – Тэмдэглэгээний шаардлага 3
A330 – Сав баглаа боодлын шаардлага 1
A410 – Эцсийн бүтээгдэхүүний микробиологийн үзүүлэлт 1
<u>A490 – Эрүүл ахуйн шаардлага 1</u>
<u>A510 – Хүйтэн/дулааны боловсруулалт 1</u>
A630 – Хүнс тэжээлийн үйл явц 2
A640 – Агуулах, тээвэрлэлтийн нөхцөл 3
A810 – Бүртгэл 1
A820 – Туршилтын шаардлага 1
A830 – Гэрчилгээжүүлэх шаардлага 1
A850 – Гарал үүслийг мөшгих шаардлага 1
A890 – Тохирлын үнэлгээ (SPS-тэй холбоотой) 1
B310 – Хаяг шошгоны шаардлага (TBT) 3
<u>B700 – Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага 1</u>
C300 – Тодорхой хилийн боомтоор нэмтрэх шаардлага 1
F710 – Хэрэглээний татвар 1

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

²³ <https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/n1nd1c6w3d82otsg/CEO%20regulation%20new%202007.pdf>

²⁴ <https://www.macmap.org/en/query/results?reporter=643&partner=496&product=0205002000&level=8>


Тайлбар: ЮНКТАД-ын ангиллаар А,В,С нь техникийн арга хэмжээ ба А-Эрүүл ахуй хорио цээрийн шаардлага; В-Худалдаан дах техникийн саад тотгор; С-Ачилтын өмнөх хяналт. F-үнийн хяналт, татвар

Дээрх хүснэгтээс харахад, ОХУ-д боловсруулсан үхрийн мах импортлоход нийт 33 тарифын бус шаардлагаас 29 нь эрүүл ахуй хорио цээрийн шаардлагыг хангахтай холбоотой зохицуулалт юм. Эдгээр шаардлагыг хэрхэн хангах талаар дараагийн бүлгүүдээс дэлгэрүүлж үзнэ үү.

3. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БЭЛТГЭЛ АЖИЛ

ОХУ-д мах экспортлохын тулд юуны түрүүн мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрт мал эмнэлэг, ариун цэврийн хянан магадлагаа хийлгэх хүсэлтийг холбогдох байгууллагад гаргаж зөвшөөрөл авах, экспортлох бүтээгдэхүүнийг гэрчилгээгээр баталгаажуулсан²⁵ байх шаардлагатай. Мах экспортлох зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангах ба боломжит импортлогч (худалдан авагч)-ийг сонгож, худалдах, худалдан авах гэрээний зүйлийг тохиролцож, олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн дагуу гэрээг баталгаажуулж, хэрэгжүүлнэ (Зураг 6).

Зураг 5. ОХУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц



3.1. МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙЛГЭХ

Монгол Улсын хувьд эрх бүхий байгууллага болох МХЕГ, МЭЕГ мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ экспортлох үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр үйл ажиллагаанд нь хянан магадлагаа хийж тухайн үйлдвэр, аж ахуйн нэгжид бүтээгдэхүүнээ экспортлох тухай зөвшөөрөл (эрх) олгодог. Тодорхой шалгуур хангасан

²⁵ Дэлхийн худалдааны байгууллагын “Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (SPS)”, МУ-1997 онд, ОХУ-2012 онд ДХБ-д элссэн.

үйлдвэрийн экспортын бүтээгдэхүүнд импортлогч орны эрх бүхий байгууллагатай харилцан тохирсон мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгодог.

Нөгөө талаас импортлогч орны эрх бүхий байгууллага (ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын алба, Россельхознадзор) экспортлогч орны эрх бүхий байгууллагын (Мал эмнэлгийн ерөнхий газар) хүсэлтээр мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хянан магадлагаа хийж, шалгалтын үр дүнгээр тухайн аж ахуйн нэгжид бүтээгдэхүүнээ ОХУ-д экспортлох эрх олгох эсэхийг шийдвэрлэдэг.

Өөрөөр хэлбэл ОХУ-ын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн экспортлох гэж байгаа компани экспортлогч орны хувьд Монголын талаас, импортлогч орны хувьд ОХУ-ын талаас экспорт импортын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл (эрх) авна. Тухайн аж ахуйн нэгж ОХУ-ын талаас тус улсад бүтээгдэхүүнээ экспортлох эрх авсан тохиолдолд ЕАЭЗХ-ны бусад гишүүн орнуудын (Белорусь, Казахстан, Киргизстан, Армян) зах зээл нээлттэй болно.

3.1.1. МАЛ АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ СОНИРХОЛ БҮХИЙ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МОНГОЛ УЛСЫН ТАЛААС ХИЙХ ХЯНАН МАГАДЛАГАА

Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох сонирхол бүхий үйлдвэр аж ахуйн нэгжүүд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт (МХЕГ) энэ тухай хүсэлтээ гаргах бөгөөд хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг МХЕГ шалгалтын хэсэг томилон дараах хяналтын хуудсаар шалгана. Эдгээр нь:

- Мах эхлэн боловсруулах үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас,
- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас,
- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас,
- Махны хадгалалтын нөхцөлийг шалгах хяналтын хуудас,
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас,
- Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас.

Хяналтын хуудсын гарын авлагыг Хавсралт №6 - Хавсралт №11-д тус тус үзүүлэв.

Хяналтын хуудас нь хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилгоос гадна хууль тогтоомж, стандартыг аж ахуйн нэгж байгууллагад сурталчилах, хяналтын хуудсыг хяналт шалгалт хийхээс өмнө бизнес эрхлэгчдэд урьдчилан хүргэснээр дотооддоо зөрчлөө илрүүлж засах боломжийг олгож байгаа юм. Үйлдвэрлэгчдэд мэдээлэл, сургамж болгон хүргэх үүднээс шалгалтын үр дүнгээр илэрсэн зарим нэг зөрчлийг Хайрцаг 1-д харуулав.

Хайрцаг 1. Монгол Улсын мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2019 онд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн шалгалтаар давхардсан тоогоор нийт 499 зөрчил илрүүлсэн байна. Илэрсэн зөрчлийн дийлэнх буюу 67.6%-89.0% хувийг:

1. Аж ахуйн нэгжүүд мал, мах бэлтгэн нийлүүлэх гэрээ байхгүй,
2. Бэлтгэн нийлүүлсэн мал нь эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээгүй,
3. Аж ахуйн нэгжүүдэд өөрийн лаборатор байхгүй,

4. Мал эмнэлгийн бүртгэл хөтлөлт хангалтгүй,
5. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны дотоод хяналт хангалтгүй,
6. Үйлдвэр цехдээ ариутгал, халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэдэггүй,
7. Үйлдвэрийн барилга байгууламжийг мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу бариагүй,
8. Үйлдвэрийг аж ахуйн аргаар, зураг төсөлгүй барьсан,
9. Мах, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг тус тусдаа хадгалах агуулахгүй,
10. Технологийн урсгал зөрчигдсөн,
11. Зарим махны үйлдвэрт хүнсний зориулалтын бус, зэврэлттэй тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл хэрэглэдэг,
12. Үйлдвэрээс гарах хаягдал түүхий эд, яс, дайврыг дахин боловсруулдаггүй, хаана хаядаг нь тодорхойгүй, бүртгэл тэмдэглэлгүй, холбогдох газартай гэрээ байгуулаагүй,
13. Зориулалтын тээврийн хэрэгсэлгүй,
14. Тээврийн хэрэгсэл халдваргүйтгэх цэггүй,
15. Тээврийн хэрэгслийн хөргөлтийн бүртгэл, журнал хөтөлж хэвшээгүй,
16. Бүтээгдэхүүний шошгонд цувралын дугаар бичээгүй,
17. Бүтээгдэхүүний гаж нөлөө, Е тэмдэглэгээ, хориглох заалтыг шошгонд бүрэн тусгаагүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн байна.

3.1.2. ОХУ/ЕАЭЗХ-НЫ ОРНУУДЫН ЗАХ ЗЭЭЛД МАЛ АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ СОНИРХОЛ БҮХИЙ ГУРАВДАГЧ ОРНЫ ҮЙЛДВЭР АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ХЯНАН МАГАДЛАГАА

ОХУ/ЕАЭЗХ-ны орнуудын зах зээлд мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох сонирхол бүхий гуравдагч орны үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийх хянан магадалгаа хийх тухай шийдвэрийг Гаалийн Холбооны комиссын 2010 оны 6-р сарын 18-ны 317 дугаар шийдвэрээр баталсан байдаг. Энэ шийдвэрийн 22-р зүйлд мал нядалгааны болон мах боловсруулах үйлдвэрүүдэд нядалсан, боловсруулсан эрүүл малын мах, хүнсний зориулалттай мах бусад түүхий эдийг Гаалийн холбооны гишүүн орнуудын хооронд шилжүүлэхийг зөвшөөрнө гээд дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- Гаалийн Холбооны нутаг дэвсгэрт экспортлоход зориулсан мах, хүнсэнд хэрэглэх мах, түүхий эдийг бэлтгэхдээ малыг нядалгааны өмнөх мал эмнэлгийн үзлэгт хамруулна. Нядалгаа хийсний дараа гулууз мах, толгой, доторх эрхтэнд нядалгааны дараах мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг хянан магадалгаа хийнэ. Мах, хүнсний зориулалттай түүхий эдийг хүнсэнд хэрэглэх боломжтой гэдгийг эрх бүхий малын эмч баталсан байна.
- Сав баглаа боодлын шошгыг савлагааг нээн задлахад бүрэн бүтэн байдлаа алдахаар хийсэн, шошгыг дахин ашиглах буюу шошгоны анхны байдлыг сэргээн засварлах боломжгүй байна.
- Мах, хүнсэнд хэрэглэх мах бусад түүхий эд нь малын халдварт өвчин илрээгүй тухай албан ёсоор тогтоосон бүсчлэлд харьяалагдах аж ахуйн нэгж, засаг захиргааны нутаг дэвсгэрээс бэлтгэсэн малын гаралтай байх ёстой. Бүх төрлийн малын хувьд:
 - Экспортлогч орны бүх нутагт эсвэл тухайн бүсчлэлд хамаарагдах засаг захиргааны нутагт сүүлийн 12 сар шүлхий өвчин илрээгүй,
 - Тухайн аж ахуйн нутаг дэвсгэрт сүүлийн 20 хоног Сибирийн боом өвчин илрээгүй байх ёстой.

ОХУ-ын эрх бүхий этгээд нь энэхүү шийдвэрийн 5 бүрдэл хэсгийн дагуу Монгол улсын махны үйлдвэрүүд, экспортлогчдод хянан магадлагаа хийж, “Мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээ хэрэгжүүлэх тухай шийдвэр” гаргасан байдаг. Энэхүү шийдвэр нь:

- Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах барааны нэгдсэн жагсаалт. Хавсралт №1 */Единый перечень товаров, подлежащих ветеринарному контролю/*
- Гаалийн холбооны орнуудын гаалийн хил болон гаалийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн журам Хавсралт №2 */Положение о едином порядке осуществления ветеринарного контроля на таможенной границе таможенного союза и на таможенной территории таможенного союза/*
- Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах объектын хамтран шалгах болон барааны дээж авах тухай нэгдсэн журам Хавсралт №3
- */Положение о едином порядке проведения совместных проверок объектов и отбора проб товаров подлежащих ветеринарному контролю/*
- Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах бараанд тавигдах мал эмнэлэг ариун цэврийн нэгдсэн шаардлага Хавсралт №4
- */Единые ветеринарно-санитарные требования, предъявляемые к товарам, подлежащим ветеринарному контролю/*
- Мал эмнэлгийн сертификатын нэгдсэн хүснэгт Хавсралт №5
- */Единые формы ветеринарных сертификатов/* гэсэн үндсэн таван хэсэгтэй.

Евразийн эдийн засгийн комиссын 317дугаар шийдвэрийн 3дугаар Хавсралтаар баталсан журмын дагуу шалгагдаж эрх авсан үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг “Гаалийн холбооны нутаг дэвсгэрт бүтээгдэхүүнээ экспортлох эрх бүхий гуравдагч орнуудын үйлдвэрүүдийн жагсаалтад (РЕЕСТР-т) бүртгэж, энэ тухайгаа ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын алба, Россельхознадзорын вэб хуудсанд байршуулдаг. Дашрамд дурьдахад зөвхөн энэ жагсаалтанд багтсан гуравдагч орны үйлдвэр, аж ахуйн нэгжүүд ОХУ/ЕАЭЗХ-ний гишүүн орнуудын зах зээлд бүтээгдэхүүнээ экспортлох эрхтэй.

Мал эмнэлгийн хяналтад хамрагдах объектын хамтран шалгах болон барааны дээж авах тухай нэгдсэн журмын (Хавсралт №3) **VI бүлэгт** Мал эмнэлгийн хяналтад хамрагдах ёстой бүтээгдэхүүн боловсруулдаг (дулааны аргаар) объектын шалгалт хийх үндсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар зааж өгчээ. Үүнд:

- Үйлдвэрлэн гаргаж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлүүдийн төслийн хүчин чадалтай харьцуулсан үзүүлэлт
- Шалгалт хийлгэж байгаа объектын гадна талбай, мал эмнэлэг, технологийн болон хөргөлтийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн болон агуулахын байгууламж, хөлдөөх болон хөргөлттэй камер, эд хогшил зэргийн мал эмнэлэг ариун цэврийн байдал
- Боловсруулалтад орох түүхий эд, үйлдвэрлэж байгаа эцсийн бүтээгдэхүүний мал эмнэлгийн дагалдах бичиг баримт ямар болох
- Үйлдвэрлэлийн байр, технологийн тоног төхөөрөмж, эд хогшил, сав баглаа боодлын ариутгал, халдваргүйтгэл
- Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнд хийх үйлдвэрийн өөрийн лабораторийн болон улсын лабораторийн хяналтын журам
- Бүтээгдэхүүний чанарын болон аюулгүй байдлын хяналтын (НАССР, ISO, СМР) тогтолцоо хэрэгжүүлдэг эсэх.

Мал эмнэлгийн хяналтад хамрагдах объектыг хамтран шалгах болон барааны дээж авах тухай нэгдсэн журмын (Хавсралт №3) **VII бүлэгт** Мал эмнэлгийн хяналтын бүтээгдэхүүнийг **хадгалах** объектын шалгалтыг дараах байдлаар хийхээр тусгасан байна. Үүнд:

- Бараа, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийн үеийн температурын горимын хяналт
- Хадгалах объектын хэмжилзүйн багаж хэрэгслээр хангагдсан байдал
- Мал эмнэлгийн хяналтын бараанд тусгайлан зориулсан экспортын бүтээгдэхүүнд тусгайлан зориулсан хөргүүртэй агуулахтай эсэх
- Үйлдвэрийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, хүнсний бус бүтээгдэхүүн, сав баглаа боодлын хадгалалтын зохион байгуулалт
- Ариутгал, халдваргүйтгэлийн цэг (дезбарьер) байгаа эсэх, түүний байдал
- Үйлдвэрийн эзэмшил газар, барилга байгууламж, агуулах болон тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйтгэл хийх, хортон мэрэгч, шавьж устгах журам
- Бэлэн бүтээгдэхүүний түр хадгалалт болон ачилтын үеийн температур-чийгшилтийн горим
- Мал эмнэлгийн хяналтын барааны ачих/буулгах, тээвэрлэлтийн үеийн мал эмнэлгийн дагалдах бичиг баримтын бүрдүүлэлт.

Экспортлогч дээрх шаардлагуудыг заавал хангасан байх ёстой.

3.1.3. ОХУ/ЕАЭЗХ-НЫ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС МАЛ ТӨХӨӨРӨХ, МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖИД ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙХ УДИРДАМЖ

Мал төхөөрөх, мах болон малын гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэр аж ахуйн газрууд мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн хянан магадлагаанд хамрагдах бөгөөд хянан магадлагаа хийж байгаа байцаагчид дараах зүйлийг анхаарч ажиллана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн план-зураг (мах ба дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүний шугам тусгаарлагдсан, салстлаг эрхтэн гүзээ, сархинаг болон, өлөн гэдэс цэвэрлэх тусдаа байртай, мах бусад эрхтэн хөргөх, хөлдөөх, хадгалах өрөө, аж ахуйн хэсэг гэх мэт) байгаа эсэх, байгаа бол үйлдвэрлэлийн технологийг түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх нэг чиглэлийн урсгалтай байх баталгааг хангахаар зохион байгуулсан, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн явцад түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний технологийн урсгал огтолцож байгаа эсэхийг тодруулах
- Шалгалтанд орж байгаа үйлдвэр аж ахуйн газар нь үндсэн үйлдвэрлэлээс гадна ахуйн болон туслах үйл ажиллагааны зориулалттай өрөө тасалгаагаар бүрэн хангагдсан байна.
- Аж ахуйн нэгжийн мал, түүхий эдийн хангалтын бүсийн халдварт өвчнөөр тайван байдал (эпизоотик): мал, түүхий эд бэлтгэлийн радиус, бэлтгэлийн тоо хэмжээ, мал бэлтгэлийг ямар, ямар аймаг, сумдаас хийдэг болохыг тогтоож, мал бэлтгэлийн бүс нутаг нь малын халдварт өвчнөөр тайван бүс нутаг мөн эсэхийг тогтоох. Тайван бус бол ямар, ямар бүс ямар өвчнөөр тайван бус байсныг тайланд тусгана.
- Түүхий эдийн бүсд малын халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байгааг бэлтгэлийн малыг дагалдаж ирсэн мал эмнэлгийн гэрчилгээ, лабораторийн дүгнэлтийг үндэслэн тогтоож ямар, ямар өвчний эсрэг вакцинжуулалт хийсэн, ямар, ямар халдварт өвчний оношлогоо хийсэн гэдгийг тэмдэглэх гэх мэт.
- Аж ахуйн нэгжийн ариун цэврийн хамгаалалтын бүс ямар болох

- Аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн байдал ямар болох, (объектуудын байршлын төлөвлөлт, бэлэн бүтээгдэхүүний хөдөлгөөний урсгал мал амьтан, түүхий эдийн хөдөлгөөний урсгалтай огтлолцож байгаа эсэх, хашааны бүрэн бүтэн байдал, үйлдвэрийн барилга байгууламж, цех, хэсгүүд түүний дотор мал баазын хашаа руу хатуу хучилттай эсвэл бетон зам байгаа эсэх
- Үйлдвэрлэлийн халуун, хүйтэн ус, уурын хангамж, хөргүүртэй агуулахын байдал, ундны усны чанарын талаар лабораторийн хяналт хийдэг эсэх
- Цэвэрлэх байгууламжийн ашиглалт (хлоржуулалт), цех доторх болон гадна сантехникийн холболт, бороо, цас, үерийн усны зайлуулалт ямар болох, үйлдвэрээс гарч байгаа бохир усны лабораторийн шинжилгээний журналыг шалгах
- Мал эмнэлэг, ариун цэврийн зориулалттай халдваргүйтгэл ариутгалын цэг (дезбарьер) байгаа эсэх, түүний ашиглалтын байдал ямар болох:
 - а) Аж ахуйн нэгжийн хашаа руу орох гарах хаалганд халдваргүйтгэлийн цэг байгаа эсэх (өвлийн цагт ариутгалын ванн дахь халдваргүйтгэлийн уусмалыг халаах боломжтой эсэх)
 - б) Амьд мал тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгслийг угаах, халдваргүйтгэл хийх цэг, талбай байгаа эсэх
 - в) Мал баазын хашаа нь малд үзлэг хийх хоолойтой эсэх,
 - г) Мал баазад, заазлагдсан (өвчтэй, туранхай) малыг тусгаарлах хорио цээрийн хашаа байгаа эсэх
 - д) Заазлагдсан (өвчтэй, туранхай) малын нядалгаа хийх, устгах, тэдгээрийн мах дотор эрхтэн боловсруулах тусгайлсан цехтэй эсэх
 - е) Заазлагдсан (өвчтэй, туранхай) малын нядалгаанаас гарсан мах, дотор мах түр хадгалах тусгаарлагдсан хөргүүртэй агуулах бий эсэх
 - ж) Малын баас, гүзээнээс гарсан ялгадас хадгалах, боловсруулах тусгайлсан талбай, төхөөрөмж, сав бий эсэх
 - з) Технологийн цех рүү орох хэсэгт ажиллагсдад зориулсан ариун цэврийн хэсэг бий эсэх (гар угаах, ариутгах хэрэгсэл, шүршүүр гэх мэт)
- Бэлтгэсэн, худалдан авсан мал, түүхий эдийн мал эмнэлгийн албан ёсны дагалдах баримт бичиг (мал эмнэлгийн гэрчилгээ эсвэл мал эмнэлгийн лавлагаа) байгаа эсэх, тэдгээрийг үнэн зөв бүрдүүлсэн эсэх
- Аж ахуйн нэгжийн мал бааз дээр нядалгааны өмнөх үзлэгийг мал эмнэлэг ариун цэврийн шаардлагын дагуу хийж байгаа эсэх, малын хашааны тав тухтай байдал
- Үйлдвэрлэлийн байр, технологийн тоног төхөөрөмж, технологийн ширээ, сав суулга, цех дотор ашигладаг тэрэг, тэргэнцэрийн халдваргүйтгэл хийдэг эсэх
- Угаалга цэвэрлэгээний болон ариутгалын бодис байгаа эсэх, тэдгээрийн хадгалалт
- Тоног төхөөрөмжийг угаах, халдваргүйтгэх механикжуулсан төхөөрөмж байгаа эсэх
- Малын эмч, мал эмнэлгийн ажилтны ажлын байрны нөхцөл ямар болох: (гэрэлтүүлэг, ариутгагч бодис, халуун хүйтэн устай угаалтуур, саван, гар ариутгах бодис бүхий ариутгалын сав, гар нүүрийн арчуур, мал эмнэлгийн зориулалтаар авсан мах, дотор махны дээж хураах сав, шаардлагатай үед мал төхөөрөх шугамыг (конвейер) яаралтай зогсоох товчлуур/кноп байгаа эсэх

- Нядалгааны дараах гулууз мах, дотор болон дайвар эрхтнүүдийн мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгийн зохион байгуулалтын байдал, гулууз махны тамгалалт үнэн зөв, тод томруун байгаа эсэх
- Мал эмнэлгийн бичиг баримтыг бүрдүүлэлтийг зөв хийж байгаа эсэх
- Мах, махан бүтээгдэхүүнийг хөргүүртэй агуулахад хадгалах байдал (мах махан бүтээгдэхүүн өрсөн байдал, температурын горим, бүртгэл)
- Стандартын бус болон заазалсан малын мах, дотор мах хүлээн авах, хадгалах, лабораторийн шинжилгээ хийх, дахин боловсруулах, устгах журам
- Үйлдвэрлэлийн байр, агуулахад температур-чийгшлийн горим зөв мөрдөгдөж байгаа эсэх, мөн тухай аж ахуй нь мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн боловсруулах, хөргөх, хөлдөөх, хадгалах, борлуулах технологийн нэгдсэн горимтой эсэх, эрх бүхий мал эмнэлгийн хяналтын байгууллагын төлөөлөгч мал эмнэлэг ариун цэврийн хяналт тавьж ажилладаг эсэх
- Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлын дотоод хяналтыг хэрхэн хийдэг болох, мах махан бүтээгдэхүүний аюулгүй байдлын бүх үзүүлэлтээр лабораторийн шинжилгээ хийдэг эсэх
- Борлуулалтанд гаргаж байгаа бүтээгдэхүүний мал эмнэлгийн дагалдах баримт бичгийг хэрхэн бүрдүүлж байгаа
- Угаалга цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн ажлын зохион байгуулалт, чанарын хяналт хэрхэн хийгдэж байгаа (үйлдвэрлэлийн шал, хана, тааз, хаалга цонх, тоног төхөөрөмж, агуулах, тээврийн хэрэгслийн угаалга, ариутгал, халдваргүйтэл гэх мэт)
- Ажилтан, ажилчдын хувийн эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг дагаж мөрдөх байдал
- Хортон шавьж, мэрэгчтэй хэрхэн тэмцдэг, мэргэжлийн байгууллагатай гэрээ хийсэн бол хэрэгжилтийн хяналт ямар болох
- Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлын дотоод хяналтын тогтолцоо бий эсэх.

Ариун цэврийн хамгаалалтын бүсэд хийх шалгалт

- Мал бааздаа гурав хүртэл өдрийн нядалгааны тоо хэмжээ бүхий мал хүлээн авах чадалтай аж ахуйн нэгжийн эзэмшил талбай орон сууцны хорооллоос 1000 метрээс доошгүй зайд байрлана.
- Хоногт 50-500 тонн мах үйлдвэрлэх хүчин чадал бүхий мал нядалгааны газар орон сууцны хорооллоос 300 метрээс доошгүй зайд байрлана.
- Мах боловсруулах үйлдвэр орон сууцны хорооллоос 300 метрийн зайд байрлаж болно.
- Хиаман цех орон сууцны хорооллоос 50 метрийн зайд байрлаж болно.
- Өдөрт 5 тонн мах боловсруулах чадалтай жижиг дунд үйлдвэр, цехүүд орон сууцны хорооллоос 50 метрийн зайд байрлаж болно.
- Экологийн хувьд тайван бус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах үйлдвэрийг барихыг хориглоно.

Үйлдвэрийн гадна талбайн байдалд хийх шалгалт

- Аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэр хоёр метрээс доошгүй өндөр, битүү хашаагаар хашигдсан байх бөгөөд үндсэн гурван бүсэд хуваагдсан байна. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн бүс (үйлдвэрлэлийн үндсэн барилга байгууламжууд байрлана)
 2. Мал баазын бүс (эцэнхий, туранхай, зайлшгүй нядалгаанд орох (зааз) мал тусгаарлах хашаа, халдварт өвчтэй болон өвчний сэжигтэй малын хорио цээрийн хашаа, зааз малын нядалгааны цех нь мал баазын бүсэд багтана)
 3. Аж ахуйн бүс (туслах чанарын барилга байгууламж, туслах материал, түлшний агуулах, сэлбэг хэрэгслийн агуулах гэх мэт)
- Аж ахуйн нэгжийн хашаа руу орох, гарах хаалганд ариутгалын уусмалаар дүүргэсэн нүхэн саад бүхий тээврийн хэрэгслийн явах эд ангийг ариутгах халдваргүйтгэлийн цэгтэй байна.
 - Үйлдвэрийн хашаан доторх барилга байгууламж хоорондын зам, талбай, төмөр зам болон автомашины ачаа ачих, буулгах тавцан, гарц, мал баазын хашаа, үйлдвэр рүү мал оруулах зам, үйлдвэрийн хашаа руу орж гарч байгаа замууд тэгш, ус нэвтрэхгүй гадаргуутай, угаах, ариутгал, халдваргүйтгэл хийхэд хялбар, асфальт бетон хатуу хучилттай байна.
 - Үйлдвэрийн хашаан доторх барилга, байгууламжуудын байршил нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:
 - хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зам, түүхий эд зөөвөрлөх зам хоорондоо огтолцохгүй байх
 - хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зам нь мал туух, малын баас ялгадас гаргах, үйлдвэрийн хаягдал зөөх замтай огтолцохгүй байх
 - эрүүл малыг нядалгааны өмнө байрлуулах хашаа руу туух зам нь өвчтэй, өвчний сэжигтэй малыг тусгаарлах болон хорио цээрийн хашаа, зааз малын нядалгааны хэсэг рүү мал туух замтай огтолцохгүй байх
 - Үйлдвэрийн барилга байгууламжийн дээврийн ус зайлуулах систем нь бороо, аадар бороо, цас мөсний хайлсан усыг зайлуулах боломжтой байх
 - Мал бааз болон өвчтэй, өвчний сэжигтэй малыг түр тусгаарлах хашаа, хорио цээрийн хашаа, зааз малын нядалгааны хэсэг, шатах тослох материалын аж ахуйгаас гарсан бохир ус нь үйлдвэрийн бусад хэсэг рүү орох ёсгүй.
 - Аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрийн чөлөөт талбайд мод, бут сөөг, тарьж зүлэгжүүлсэн, ажилчдын түр амрах бүс байгууламжийг тохижуулсан байна.
 - Өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэр, (мал баазын хашаа орно) үйлдвэрлэлийн байгууламжуудыг цэвэр байлгаж, өдөр бүр цэвэрлэгээ хийдэг байна. Дулааны улиралд, цэвэрлэгээ хийхийн өмнө зам талбай, ногоон байгууламжуудыг услах хэрэгтэй. Өвлийн улиралд зам, явган хүний замын цас, мөсийг заавал арилгах хэрэгтэй.
 - Үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг тагтай төмөр сав эсвэл контейнерт хийнэ. Хогийн савыг түүний суурийн хэмжээнээс гурав дахин том асфальтан талбайд байрлуулах бөгөөд гурван талаасаа хаалттай битүү байна. Хогийн сав нь үйлдвэрлэлийн үндсэн болон туслах байгууламжаас 25 метрээс доошгүй зайд байрласан байна.
 - Хогийн сав 2/3 хүртэл дүүрсэн тохиолдолд хогийг зайлуулна. Өдөрт нэгээс багагүй удаа хог ачдаг байна. Хоосорсон савыг угааж халдваргүйтгэл хийдэг байна.
 - Үйлдвэрлэлийн үндсэн болон туслах цех, хэсгүүд болон агуулахуудын байршил нь үйлдвэрлэлийн технологийн дэс дараалал, хөдөлгөөний урсгалын огтлолцохгүй байх зарчмыг хангаад зогсохгүй үйлдвэрлэж байгаа мах, махан махан бүтээгдэхүүн, түүхий

эдийн аюулгүй байдлын мал эмнэлэг ариун цэврийн хяналт хийх боломжоор хангасан байх ёстой. Мөн цэвэрлэгээ, угаалга, халдваргүйтгэлийн чанарын хяналт тавих боломжоор хангасан байх ёстой.

- Үйлдвэрийн мал эмнэлэг, ариун цэврийн зориулалттай байгууламжууд хэвийн ажиллагаатай байх ёстой. Үүнд:
 - Аж ахуйн нэгжийн хашаа руу орох гарах хаалганы халдваргүйтгэлийн цэг нь өвлийн цагт халдваргүйтгэлийн шингэнийг халаах боломжтой байна.
 - Амьд мал тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгслийг угаах, халдваргүйтгэл хийх цэг, талбай ажиллагаатай байна.
 - Мал баазын хашаа нь малд үзлэг хийх хоолойтой байна.
 - Мал бааз нь заазлагдсан (өвчтэй, туранхай, өвчний сэжигтэй) малыг тусгаарлах хорио цээрийн хашаатай байна.
 - Заазлагдсан малын нядалгаа хийх, устгах, тэдгээрийн мах, дотор эрхтэн боловсруулах тусгайлсан цехтэй эсэх
 - Заазлагдсан (өвчтэй, туранхай) малын нядалгаанаас гарсан мах, дотор махыг түр хадгалах тусгаарлагдсан хөргүүртэй агуулахтай байна.
 - Малын баас, гүзээнээс гарсан ялгадас хадгалах, боловсруулах, тусгайлсан талбай, төхөөрөмж, савтай байна.
 - Технологийн цех рүү орох хэсэгт ажиллагсад зориулсан ариун цэврийн хэсэг нь гар угаах, ариутгах хэрэгсэл, шүршүүртэй байна.
- Үйлдвэрлэл дээр угаалга цэвэрлэгээний болон ариутгалын бодисын нөөц хангалттай байхаас гадна ажиллагсад ээлжийн гутал хувцас, хормогч, гуталтай байна.
- Үйлдвэрлэлийн байгууламж, байр, технологийн тоног төхөөрөмж, сав суулга, цех дотор ашигладаг тэрэг, тэргэнцэр, түүнчлэн амьд мал тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгслийн угаалга, халдваргүйтгэлийг мал эмнэлэг ариун цэврийн норм, нормативын шаардлагад нийцүүлэн зохих удирдамжийн дагуу хийдэг байна.

Мал баазын нөхцөл байдлын шалгалт

- Мал бааз нь үйлдвэрлэлийн хэсгээс тусдаа 2 метрээс доошгүй өндөр битүү хашаатай байх ба дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - Малын эмч, ажилтнуудын ажлын өрөө тасалгаа
 - Мал хүлээлгэн өгч байгаа хүмүүс байрлах ахуйн болон хувцас ариутгах өрөө
 - Тээврийн хэрэгслээс мал буулгах тавцан
 - Малын пүү
 - Малын баас, өтөг бууц түр хадгалах сав
 - Мал эмнэлгийн үзлэг, цус авах хоолой/хүзүүвч
 - Битүү халхавч бүхий малын хашаа
 - Амьд мал тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгслийг угаах, халдваргүйтгэх цэг
 - Өвчтэй болон өвчний сэжигтэй, зайлшгүй нядалгаанд орох малыг (заазлагдсан мал) түр тусгаарлах/карантин хэсэг (энэ хэсэгт малын цогцсонд мал эмнэлгийн үзлэг хийх тусгай өрөө, цогцос зайлуулах тэргэнцэртэй байна)
 - Зааз малын нядалгааны цех. Цехэд орох малыг тусгайлан гаргасан хаалгаар оруулах ба өвчтэй мал хүлээн авах хэсэг, мал эмнэлгийн үзлэг хийх, малын халуун хэмжих талбайтай байна

- Үйлдвэрийн стандарт хангахгүй эцэнхий, туранхай мал тусгаарлах хэсэг
- Хорио цээрийн карантины болон тусгаарлах хэсгийн шал, хана, малын тэжээлийн болон усны сав бусад хэрэгсэл нь ариутгал, халдваргүйтгэл хийхэд хялбар материалаар хийгдсэн байх ёстой. Модоор хийгдсэн эд зүйл байж болохгүй. Хорио цээрийн карантины болон тусгаарлах хэсгийг өдөр бүр өтөг бууц, малын бааснаас цэвэрлэж, угааж ариутгаж байх хэрэгтэй.
- Хорио цээрийн карантины хашаа болон тусгаарлах хэсэг, зааз мал нядлах цех, мал баазад ирсэн тээврийн хэрэгслийн ариутгах цэгээс гарсан бохир ус, баасыг механик бохирдол баригчаар дамжуулан хлоржуулалт хийсний дараа төвийн бохирын систем рүү оруулна.
- Зааз малын нядалгааны цех, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шаардлага гарсан тухай бүр угааж цэвэрлэх ба ажил дууссаны дараа халдваргүйтгэл хийнэ.
- Мал хүлээн авах хашаа нь нэг машинд ачиж ирсэн малыг бүрэн багтаах боломжтой байна. Өөрөөр хэлбэл мал хүлээн авах нэг хашаанд хэд, хэдэн машинд ачигдаж ирсэн малыг хооронд нь хольж хашиж болохгүй. Туувраар ирсэн мал хүлээн авах хашаа нь нэг суурь мал багтаах хэмжээтэй байна.
- Мал хүлээн авах хашаа нь бороо, цас, нарнаас хамгаалах дээвэртэй, хатуу хучилт бүхий шалтай, тэжээл өгөх сав, мал услах онгоц, онгоц руу ус өгөх шланг, мал уях уяатай байна. Хашааг заагласан төмөр хаалтууд нь мал гэмтхээргүй байна. Хашаа бүрт түүнд байгаа малын төрөл, тоо хэмжээг заасан пайз байрлуулна.
- Хашааг өдөр бүр цэвэрлэж баасыг мал эмнэлгийн хяналтын байгууллагын зааж өгсөн хогийн цэгт хаяна. Өвчтэй болон өвчний сэжиг бүхий малыг тусгаарлах, нядлахдаа зохих хууль, дүрэм журмыг дагаж мөрдөнө.
- Малын өтөг бууц, баас зөөвөрлөж байгаа тээврийн хэрэгслийг өдөр бүр угааж цэвэрлэж, халдваргүйтгэл хийж энэ тухай тэмдэглэл хөтөлнө.
- Малын өтөг бууц, баасыг биологийн аргаар боловсруулдаг бол эдгээр төхөөрөмжүүдийг мал эмнэлгийн хяналтын байгууллагын зааж өгсөн талбайд байрлуулсан байна.

Усан хангамж, татуургын системийн хяналт

- Аж ахуйн нэгж нь хангалттай хэмжээний халуун, хүйтэн ундны усаар хангагдсан байх ёстой. Төвийн усан хангамжаас усаа татдаг бол улиралд нэг удаа, өөрийн усан хангамжтай бол (гүний худаг) сард нэг удаа ундны усны аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар лабораторийн шинжилгээ хийлгэх ёстой. Усан хангамжийн байгууламжууд (гүний худаг) нь ариун цэврийн хамгаалалтын бүсийг заагласан хашаа, байнгын хяналт, хамгаалалттай байх ёстой.
- Төвийн цэвэр усны шугамаас ус татаж буй хэсэг нь техникийн болон ариун цэврийн хэвийн нөхцөлтэй, манометр, усны дээж авах цорго, бохир ус зайлуулах суваг/трап, усыг зөвхөн нэг чиглэлд явуулах хавхлагатай, тусгаарлагдсан түгжээтэй өрөөнд байх ёстой. Аж ахуйн нэгж нь өөрийн ус сувгийн схем-зурагтай байх ёстой бөгөөд хяналтын байгууллагын шаардлагаар үүнийг үзүүлэх хэрэгтэй.
- Зүлэг, мод услах, газар чийглэх, автомашины гадна угаалга зэрэгт саарал/техникийн ус ашиглаж болно. Гагцхүү техникийн усны хоолой нь цэвэр усны хоолойноос тусдаа явах бөгөөд өөр өнгөтэй байна.

- Ундны болон гал унтраах зориулалттай ус хадгалах усан сан дор хаяж хоёр байх ёстой. Усан сангийн усны солилцоо 48 цагаас (2 өдөр) илүүгүй хугацаанд хийгдэж байх ёстой. Усан сан нь түүний дотор талын цэвэрлэгээ хийх, шалгах зориулалт бүхий шат, орох нүхтэй байна.
- Усан санд байгаа усны чанар, аюулгүй байдлыг зохих норматив бичиг баримтын дагуу халдваргүйтгэж байнгын хяналтаар хангасан байна.
- Усан сангийн усны сав, усан хангамжийн сүлжээг засварын ажил эсвэл ямар нэг ослын дараа халдваргүйтгэх шаардлагатай.
- Үйлдвэрлэлийн байрны 150 метр квадрат талбай бүрт ус шүрших зориулалтын крант/хаалт, уян хоолой/шланг байрлуулсан байна.
- Үйлдвэрлэлийн цех бүрт халуун хүйтэн усны холигчтой гар угаалтуур/раковина байна. Угаалтуурын хажууд саван, сойз, халваргүйтгэлийн уусмал бүхий сав, нэг удаагийн гарын арчуур, эсвэл гар хатаагч байх ёстой.
- Гар угаалтуурыг цех рүү орох хэсэгт заавал байрлуулах ба цех дотор бол ажлын байрнаас 18 метрээс илүүгүй зайд, тохиромжтой байрлалд байрлуулна.
- Үйлдвэрт, ажлын байрнаас 75 метрээс ихгүй зайд цэвэр ус уух төхөөрөмж байрлуулах ба усны хэм нь 8° C-ээс доошгүй 20° C-ээс ихгүй байна.
- Үйлдвэрлэлийн байрны 150 метр квадрат талбайд нэг байхаар тооцож шингэн зайлуулах 10 см диаметр бүхий сараалжин тортой суваг/трап хийж өгнө.
- Технологийн тоног төхөөрөмж, машин, байгууламжаас гарах ашигласан усыг зайлуулах хоолойд сараалжин тор суурилуулан үйлдвэрийн ерөнхий ус сувгийн хоолойтой холбоно.
- Аж ахуйн нэгж нь үйлдвэрийн ашигласан ус, бохир ус, хурын ус зайлуулах өөрийн ариутгалын татуургын системтэй байх бөгөөд үүнийг төвлөрсөн ариутгах татуургын сүлжээд эсвэл өөрийн цэвэрлэх байгууламжинд холбосон байна. Төвийн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бохир ус нь зохих норм, нормативт заасан үзүүлэлтүүдийг хангасан байх сөтой.
- Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлж байгаа бохир усны шинжилгээг үйлдвэрлэлийн лабораторид эсвэл магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ.

Гэрэлтүүлэг, агааржуулалт, халаалтын системд хийх шалгалт

- Үйлдвэрийн байрны гэрэлтүүлэг нь зохих нормативд заасан эрүүл ахуй, ариун цэврийн хэм, хэмжээг хангасан байх ёстой.
- Үйлдвэрийн байрыг “өдрийн гэрлээр” (люминесцентные лампы) гэрэлтүүлдэг бол гэрлийн шилийг унахаас хамгаалсан хамгаалалтын бүрхүүл, ердийн “улайсдаг чийдэн”-гээр гэрэлтүүлдэг бол чийдэнгийн гадуур шилэн бүрхүүл хийсэн байх хэрэгтэй.
- Хүмүүс байнга байдаг үйлдвэрийн цех нь байгалийн гэрэлтэй байх шаардлагатай. Үйлдвэрлэлийн технологийн шаардлагаар ажиллагсад ажлын цагийн 50 хүртэл хувийг өнгөрүүлдэг ажлын байранд байгалийн бус гэрэлтүүлэг байж болно.
- Үйлдвэрийн гадна болон дотор талд гэрлийн тусгалыг ямар нэг зүйлээр хааж болохгүй.

- Боловсруулах цех рүү орж ирж байгаа агаарыг тоос, бусад механик бохирдлоос цэвэрлэх агаар шүүх төхөөрөмжөөр дамжуулан оруулах хэрэгтэй. Гаднаас татах агаарыг аль болох агаарын бохирдол бага байх магадлалтай хэсгээс авна.
- Уур болон их хэмжээний дулаан ялгаруулдаг цехэд агаар гадагшлуулах салхивч, сорох сэнс байрлуулахаас гадна технологийн горимд харшлахгүй бол байгалийн агааржуулалттай байж болно.
- Агааржуулалтын суваг, технологийн тоног төхөөрөмжийн агаар сорох, гаргах хэсгийг үе үе цэвэрлэж бүртгэл хөтөлж байх ёстой.
- Үйлдвэрлэлийн болон туслах цехийн өрөө, тасалгаа нь дулаанаар хангагдсан байх ёстой. Агаарын температур, харьцангуй чийгшил нь норматив бичиг баримтанд заасан үзүүлэлтүүдийг хангаж байх ёстой.
- Халаах хэрэгсэл нь бүтэц, хэлбэрийн хувьд цэвэрлэж засварлахад хялбар байх сөтэй.
- Технологийн процессын үйл ажиллагаа, мал эмнэлэг-ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тухайн орны (үндэсний) хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөх ёстой.

Үйлдвэрлэлийн үндсэн болон туслах цехийн шалгалт

- Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн цех, тасгууд нормативын дагуу технологийн үйл ажиллагааг зохион байгуулахад нийцсэн байхаас гадна түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний урсгал огтлолцохгүйгээр төлөвлөгдсөн байх ёстой. Технологийн хувьд цэвэр бохир бүсийг заагласан ханатай байна. Хүнсний болон техникийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх байр бие биенээсээ тусгаарлагдсан байна. Үйлдвэрлэлийн цехүүдийн үүдэнд ариутгалын бодистой дэвсгэр/коврик байрлуулсан байх ёстой.
- Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах цех болон угаах, цэвэрлэх хэсгийн хана, баганын гадаргуу гялгар плитагаар наасан эсвэл цагаан, цайвар өнгийн тосон будагтай байж болно. Хана, баганын өндөр 2 метрээс доошгүй байна. Цехийн ханын плита, будаг ховхорсон, гэмтсэн байж болохгүй.
- Цехийн доторх шугам хоолойнуудыг ялгаатай өнгөөр будаж, цэвэр байлгах хэрэгтэй.
- Цех дотор тэргэнцэрийн хөдөлгөөний зам дагуу байрлах баганы булангуудыг нэг метрийн өндөртэй, зэвэрдэггүй ган материалаар хамгаалж, хаалганы доод талыг 0.5 метрийн өндөртэй метал листээр бэхэлсэн байх ёстой.
- Үйлдвэрлэлийн бүх өрөөний шал нь эвдрэлгүй, ан цавгүй, нүхгүй, ус үл нэвтрэх гадаргуутай, ус, шингэн орох суваг/трап руу чиглэсэн налуу байх ёстой. Хана шалны уулзвар нь тэгш өнцөг бус, угаалга цэвэрлэгээ хийхэд хялбар мохоо өнцөгтэй байна.
- Үйлдвэрлэлийн үндсэн, туслах, ахуйн зориулалтын байрны урсгал засварыг шаардлага гарсан үед хийх боловч хагас жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Хана, таазны будгийн ажлыг хийхдээ халдваргүйтгэлийн ажлыг хамт гүйцэтгэж болно.
- Өөх тос боловсруулах, мах боловсруулах зарим цехэд үйлдвэрлэлийн процессын улмаас шал, хана өөх тосоор бохирддог тул өдөрт хоёроос доошгүй удаа халуун савантай уусмал эсвэл өөх тос арилгах бодисоор угааж тэмдэглэл хөтөлнө.
- Үйлдвэрлэлийн үндсэн, туслах, ахуйн зориулалтын бүх байр үргэлж цэвэр байх ёстой. Үйлдвэрлэлийн үндсэн байрны шалыг угааж цэвэрлэхдээ хүнсний түүхий эд боловсруулдаг, эцсийн бүтээгдэхүүнтэй харьцдаг технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалыг бохирдуулахгүй байх хэрэгтэй.

- Үйлдвэрлэлийн байрны цэвэрлэгээ, технологийн тоног төхөөрөмж, хүсний түүхий эд, материал зөөдөг тэргэнцэрийн ариутгалыг норматив бичиг баримтад заасан хугацаанд, заасан арга барилаар хийж байх ёстой.
- Цонхны дотор талын рам, шилийг 15 хоногт нэг удаа, гадна талыг бохирдсон үед нь угааж байна. Зуны улиралд онгойлгодог цонх ялааны тортой байна.
- Цехийн доторх бүх хаалгыг өдөр бүр угааж, гадаргууг хуурай болтол арчина, ялангуяа хаалганы бариул, түүний ойр орчмын хэсэг, хаалганы доод талыг сайтар арчиж цэвэрлэх хэрэгтэй. Хаалганы гадна талыг шаардлагатай үед арчиж, цэвэрлэж байна.
- Бохир усны трап, тосгуурыг өдөр бүр угааж халдваргүйтгэл хийх ба туузан дамжуурга, технологийн конвейер, лифтийг ээлжийн дараа цэвэрлэж байна.
- Үйлдвэр нь хангалттай хэмжээний цэвэрлэгээний багаж хэрэгсэл, угаалгын нунтаг, ариутгагч бодистой байх ёстой ба тэдгээрийг тусгаарлагдсан өрөөнд, шүүгээнд хадгалах ёстой. Цэвэрлэгээний багаж хэрэгсэл нь үйлдвэрлэлийн аль хэсэгт цэвэрлэгээ хийхээс хамааран өөр өөрийн ялгах тэмдэгтэй байна. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээний багаж төхөөрөмжийг тусад нь хадгалах хэрэгтэй.
- Үйлдвэр нь сар бүр их цэвэрлээгээ хийх өдөртэй байна.

Үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж, бусад хэрэгслийг шалгах

- Үйлдвэрлэлд хэрэглэж байгаа технологийн тоног төхөөрөмж, сав суулга, эд хогшил нь хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах зориулалт бүхий химийн нөлөөлөлд тэсвэртэй, зэвэрдэггүй материалаар хийсэн байна.
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг байрлуулахдаа үйлдвэрлэлийн ариун цэврийн зохих түвшинг хангах, технологийн сөрөг урсгал байхгүй байхаар тооцно. Тоног төхөөрөмжийн бүтэц, хэв загвар нь түүнийг угааж цэвэрлэх, ариутгал, халдваргүйтгэл хийх боломжийг хангасан байх ёстой.
- Технологийн зориулалт бүхий төмөр тогоо, ванн, сав суулга, шүүрэн шанага цэвэрлэхэд хялбар гөлгөр гадаргуутай байна.
- Ширээ нь элдэв нүх сүвгүй жигд тэгш гадаргуутай байна. Дээрээс унаж ирж байгаа түүхий эд хүлээн авах ширээ нь түүхий эдийг шалан дээр унахаас хамгаалсан хаалттай байна. Мах шулах, ангилах цехэд цэвэрлэх, (механик бохирдол, үс хялгас, бүлх, булчирхай, шөрмөс салгах) ариутгал, халдваргүйтгэл хийхэд хялбар зориулалтын тавцан хэрэглэх хэрэгтэй. Ээлжийн дараа эдгээр тавцанг ариутгаж халдваргүйтгэн халуун уураар сайтар цэвэрлэнэ.
- Хутга, хутга ирлэгч ашигладаг цех бүрт эдгээрийг ариутгах төхөөрөмж/стерилизатор (усны хэм 82°C) суурилуулсан байх шаардлагатай. Харин эргэлтийн сагс, бусад сав суулга ашигладаг бол халуун (усны хэм 82°C), хүйтэн усны оролттой сав угаагч машинтай байх шаардлагатай.
- Технологийн тоног төхөөрөмжийг цэвэрлэх, угаах, халдваргүйтгэх үйлдэл нь технологийн процессийн салшгүй нэг хэсэг болсон байх ёстой ба цех бүрт энэ ажлыг хийх тодорхой хуваарь байх ёстой.

Мал баазад мал хүлээн авах ажиллагааг шалгах

- Махыг халдвараас сэргийлэх, өвчтэй эсвэл доройтсон малыг нядлах цехэд оруулахгүй байх үүднээс нядлахын өмнө амьд малд нядалгааны өмнөх мал эмнэлэг ариун цэврийн үзлэг хийж, зөвхөн эрүүл малыг нядалгааны малд зориулсан хашаанд оруулна.
- Өвчтэй, халдварт өвчний шинж тэмдэгтэй эсвэл зайлшгүй шаардлагаар нядлах (хүнд гэмтэл авсан, босох чадваргүй, тулгуур эрхтний гэмтэлтэй, түлэгдсэн, амьсгал нь боогдсон гэх мэт) малыг нядлах бол энэ тухай Гаалийн холбооны орнуудын холбогдох техникийн зохицуулалт бусад хууль дүрэм, мал эмнэлэг ариун цэврийн журмыг мөрдөнө.
- Нядалгаанд орох мал нь халдварт өвчнөөр тайван бүс нутгаас бэлтгэсэн, орон нутгийн эрх бүхий мал эмнэлгийн байгууллагаас олгосон мал эмнэлгийн гэрчилгээтэй байна. Мал эмнэлгийн гэрчилгээнд тухайн мал, мал эмнэлгийн үзлэгт орсон бөгөөд эрүүл гэдэг нь нотлогдсон, эрүүл бүс нутгаас бэлтгэсэн, төлөвлөгөөт вакцинжуулалтанд хамрагдсан, хамгийн сүүлд хийсэн/уусан антибиотик, гормоны эм бэлдмэлийн нэр, хугацааг бичсэн байна.
- Вакцин тарьснаас хойш 21, антибиотик, туулга, гадна шимэгчдийн эсрэг бэлдмэл хэрэглэснээс хойш 14-21 хоног болоогүй малыг хүлээн авахгүй, нядлахыг хориглоно.
- Малыг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр эсвэл туувраар тууж ирж болно.
- Нядалгааны өмнөх мал эмнэлгийн үзлэгийг зохих хууль дүрмийн дагуу хийх ба үйлдвэрийн удирдлага малын эмч нарт үзлэг хийх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байх үүрэгтэй.
- Мал хүлээн авч байгаа малын эмч, мал эмнэлгийн дагалдах бичиг баримтын үнэн зөв байдлыг шалгаж мал эмнэлгийн үзлэг хийж эрүүл малыг нядалгааны өмнөх хашаанд, өвчтэй, сэжигтэй мал байвал тусгаарлах хашаанд оруулна. Малын эмч хүлээн авсан малын мал эмнэлгийн хяналтыг нядалгаа хүртэл тавих бөгөөд хүлээн авсан мал хашаанд орсноос хойш 24 цагийн дотор нядалгаанд орвол шууд, 24 цагаас илүү хугацаанд хашаанд байсан бол нядалгааны өмнөх үзлэгийг давтан хийнэ.
- Өвчтэй болон замдаа үхсэн малын цогцосноос авсан дээжийн шинжилгээг зөвхөн улсын мал эмнэлгийн лабораторт хийнэ.
- Аж ахуйн нэгжийн малын эмч мал хүлээн авах үед илрүүлсэн халдварт өвчтэй малын тухай мэдээллийг бүс нутгийн/дүүргийн малын ерөнхий эмч болон малын эзэн хоёрт яаралтай мэдээлнэ.
- Нядалгааны өмнөх мал эмнэлгийн үзлэгээр эрүүл гарсан малыг нядалгаанд оруулах бөгөөд эдгээр малыг нядалгааны цехэд удаахгүй төхөөрөх хэрэгтэй.

Мал нядалгааны технологийн явц, мал эмнэлэг ариун цэврийн үзлэгийн хяналт

- Мал нядлах үйлдвэр нь нядлах технологийн дамжлагын дагуу муужруулах, цусыг юүлэх, толгойг салгах, арьс ширийг өвчиж хуулах, дотор эрхтэн, үржлийн эрхтэн, давсаг, шийр, дэлэнг гулуузаас салгах, гулууз мах, дотор эрхтэн (элэг, зүрх, бөөр, уушиг, өрц, тархи, гүзээ, сархинаг, ходоод, гэдэс, цөвдөл мах, өөх), дайвар бүтээгдэхүүн (толгой, шийр, цус, дотоод шүүрлийн булчирхайнууд, хүнсний бус бусад эрхтэн: дэлүү, үржлийн эрхтэн, шөрмөс) боловсруулах, хөргөх, хөлдөөх, хадгалах үйл ажиллагаа явуулна.
- Мал муужруулах үйлдэл нь нядалгаанд оруулж байгаа малыг тэр дор нь үхүүлэхгүй, бүрмөсөн үхсэн малыг цаашдын технологийн процесст оруулахааргүй байна. Муужруулсан малын цусыг юүлж дуустал малын зүрх ажиллагаатай байх ёстой.

- Цус юүлэх процесс нь малыг муужруулснаас хойш 1.5-3.0 минутын дотор эхлэж 6-8 минутын дотор дууссан байх ёстой.
- Мал нядалгааны ээлж дуустал муужруулах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг 2-3 удаа шалгаж байх ёстой.
- Бод малын цусыг цаашид боловсруулах зорилгоор хуримтлуулах бол хуримтлуулах савны ариутгалыг сайтар хангаж савнуудыг нядалгаанд орсон малын дугаартай адил дугаараар дугаарласан байх ёстой бөгөөд нэг саванд нэг л малын цусыг юүлсэн байна. Юүлж авсан цусыг, цус бүлэгнүүлэхгүй байлгах төхөөрөмжөөр тоноглож бэлтгэсэн өрөөнд 30-40 минут буюу цусыг нь авсан малын мах, дотор эрхтэн, толгойд мал эмнэлгийн үзлэг хянан магадлагаа хийж дуустал хадгална. Мал эмнэлгийн үзлэгт тэнцсэн малын цусыг цаашдын боловсруулалтанд оруулна.
- Мал нядлах үед нэг малаас гарч байгаа гулууз, толгой, дотор эрхтнүүд, өлөн гэдэс, арьсыг ижил дугаараар дугаарлана.
- Нядалгаанд орж байгаа малын цусалгаа хийсний дараа арьс хуулахдаа гулууз махыг бохирдуулахгүй, механикаар гэмтээхгүй, арьсыг зүсэж гэмтээх, арьснаас тоос шороо босгох зэрэг эрсдэлийг аль болох бага байлгах хэрэгтэй.
- Нядалгаанд орж байгаа малын гэдэс, дотор эрхтнийг цусалгаа хийснээс хойш 30 минутын дотор авсан байх ёстой. Энэ үед малын ходоод, гэдсийг хагалж, гулууз махны дотор, гадна гадаргуу, дотор эрхтэн, тэдгээртэй харьцаж байгаа ширээ, багаж, тоног төхөөрөмжинд бактерийн бохирдол үүсгэхийг хориглоно.
- Мал нядалгааны цех нь стандартын шаардлага хангасан халуун $+82^{\circ}\text{C}$ -ийн/, хүйтэн устай байна.
- Мал нядалгааны үйлдвэрт технологийн тоног төхөөрөмж, дамжлагын конвейерийг суурилуулахдаа нядалгааны дамжлагын дагуу гулууз мах, дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг хийх малын эмч болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарын ажлын байрыг давхар тоноглогосон байх шаардлагатай.
- Малын эмч, мал эмнэлгийн хяналтын байцаагч нарын ажлын байранд нэмэлт гэрэлтүүлэг, ариутгагч бодис, халуун хүйтэн устай угаалтуур, саван, гар ариутгах бодис бүхий ариутгалын сав, гар нүүрийн арчуур, мал эмнэлгийн зориулалтаар авсан мах, дотор махны дээж хадгалах сав, шаардлагатай үед (онц халдварт өвчтэй болон өвчний сэжигтэй мал илрүүлсэн үед) мал төхөөрөх шугамыг (конвейер) зогсоох аваарын товчлуурыг байх шаардлагатай.
- Мал нядалгааны цехэд өвчтэй болон өвчний сэжигтэй малын гулууз мах, дотор эрхтнийг зөөвөрлөх нэмэлт дүүжин зам, эдгээрийг түр хадгалах хөргүүртэй агуулах байх шаардлагатай. Хөргүүртэй агуулахыг тусгайлан бэлтгэсэн газар байгуулах ба энэ агуулахын түлхүүр мал эмнэлгийн хяналтын байцаагч нарт байна. Өвчтэй болон өвчний сэжигтэй малын мах, дотор эрхтнээс авсан дээжинд хийсэн мал эмнэлгийн шинжилгээний дүгнэлт гартал мах, дотор эрхтнийг дээр дурьдсан түр агуулахад улсын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарын хяналтын дор хадгална. Мал эмнэлгийн шинжилгээг зөвхөн улсын мал эмнэлгийн лабораторт хийнэ.
- Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг хийх малын эмч болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарын ажлын байргүй болон дутуу тоноглогосон мал нядалгааны цехийг ажиллуулахыг хориглоно.

- Нядалгааны дараах мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, хянан магадлагааг дараах байдлаар хийнэ. Үүнд:
 - Зүрхэнд цистицеркоз, саркоцистоз зэрэг бусад өвчний шинж тэмдгийг хайх зүсэлт хийж үзнэ,
 - Уушигны салбангуудыг барьж үзнэ, зүүн гуурс, трахеогуурс, тунгалгийн зангилааны зүсэлт хийж трихинеллёз идээт үрэвсэл, зэрэг өвчний шинж тэмдгийг хайна,
 - Элэгний үзлэгийг цөсийг салгасны дараа хийнэ. цөс хагарсан тохиолдолд үзлэгийн ширээний тавцанг заавал цэвэрлэнэ,
 - Бөөрний бүрхэвчийг (капсул) салгасны дараа бөөрөнд зүсэлт хийнэ, бөөрийг тэмтэрч үзнэ,
 - Дэлүүнд гаднах байдал болон зүсэлтийн үзлэг хийж шалгана.
- Хяналтын байцаагчийн үзлэг, лабораторийн шинжилгээгээр ямар нэгэн өвчний шинж тэмдэг илрээгүй, гэмтэлгүй, хяналтын тэмдэг дарагдсан, зохих журмын дагуу технологийн боловсруулалт хийсэн, үйлдвэрийн дугаар, малын эмчийн тамга дарсан гулууз, дотор эрхтэн бусад бүтээгдэхүүнийг сэврээх, хөлдөөх камерт оруулна.
- Мал эмнэлэг эрүүл ахуйн хяналт шалгалтын явцад хураагдсан мах, дотор эрхтэнг тусгай хоолойгоор гулсуулан түр хадгалах саванд хийх, эсвэл зориулалтын таг, түгжээтэй ялгах өнгөөр будсан (цагаан дэвсгэр дээр хар зураас зурах гэх мэт) явуулын битүү саванд хийнэ. Саван дээр “Дахин боловсруулалтанд оруулах”, “Хаягдал”, “Устгалд оруулах” гэх мэт хаяг бичсэн байна.
- Нядалгааны малын сархинаг, гүзээний баас асгах болон арьс шир боловсруулах хэсгийг мал төхөөрөх цехээс тусгайлан байгуулж 3 метрээс дээш өндөртэй хашаагаар хашсан байна.
- Хүнсний түүхий эд (өөх тосны түүхий эд, өлөн гэдэс, дотор эрхтэн гэх мэт) зөөвөрлөх төрөл бүрийн сагс, дамжуулах хоолой, тэргэнцэр нь зөөвөрлөж байгаа түүхий эд, материалын төрөл бүрээр тусдаа ангид байх ба цэвэрлэх, угаах, ариутгах боломжтой байх ёстой (эдгээрийг өнгөөр ялгах, түүхий эдийн нэрийг бичих, дугаарлах, цехийн нэр бичих зэргээр хооронд ялгаж болохоор тэмдэг тавина).
- Өлөн гэдэс боловсруулах цехийн тоног төхөөрөмж, ажлын байр, ус сувгийн хоолойн байршил нь гэдэсний өнгөр болон гэдэс угаасан усаар бохирдохгүй байхаар зохион байгуулагдсан байна. Гэдэсний өнгөрийг тусгай саванд цуглуулж мал эмнэлгийн байгууллагын зааж өгсөн цэгт хаяна.
- Өлөн гэдэс боловсруулах цех нь халуун, хүйтэн устай, эцсийн боловсруулалт хийдэг бол тухайн цехэд гэдэс үлээх агаарын сувагтай байна.
- Өлөн гэдэсний боловсруулалт хийж байгаа ажилчдын ажлын байр нь хальтаргаа гулгаанаас хамгаалсан хөлийн гишгүүртэй байна.
- Ясны тос гаргах зорилгоор яс бутлах, хөрөөдөх, жижиглэх ажлыг тосон цехэд тусгалан гаргасан ажлын байранд зохион байгуулна.
- Дахин боловсруулалт хийх мах, дайвар бүтээгдэхүүний чаналгыг дулааны боловсруулалтын болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цехэд хийж болохгүй. Энэ боловсруулалтыг цахилгаан эсвэл хийн зуухаар тонолосон, үйлдвэрлэлийн бусад өрөөнөөс тусгаарласан ажлын байранд хийнэ. Дахин боловсруулалт хийх түүхий эдийг үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүнтэй холилдохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой.

- Стандартын бус махны боловсруулалтыг зөвхөн улсын мал эмнэлгийн байцаагчийн хяналтын дор хийж гүйцэтгэнэ.
- Хүнсний бус хог хаягдлыг тусгай саванд эсвэл үлээлгэх цистернд цуглуулж, бусад тоног төхөөрөмжөөс ялгаатай өнгөөр будах эсвэл зориулалтыг илтгэх тэмдэг, тэмдэглэгээ хийсэн байна.


Хайрцаг 2. Монголын мах боловсруулах үйлдвэрүүдэд Гаалийн холбооны орнуудын мэргэжилтнүүдийн хамтарсан шалгалтаар илэрсэн нийтлэг дутагдал

1. Евразийн /Гаалийн Холбоо болон ОХУ-ын мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага, нормын дагуу мах махан бүтээгдэхүүнд хүнд метал (мөнгөн ус), антибиотик (левомицинаас бусад), пестицид, диокстин, микробиологийн үзүүлэлтүүдээр (сальмонел, *L.monocytogenes*) лабароторын шинжилгээ хийсэн тухай нотлох журнал хөтөлдөггүй.
2. Бүтээгдэхүүн хадгалах дүрмийн зөрчлүүд байна: Хөргүүртэй агуулахад махтай хамт сүүн бүтээгдэхүүн (мөхөөлдөс), мал эмнэлгийн тамгагүй, хаяг шошгогүй махыг овоолж хадгалсан байна.
3. Зарим үйлдвэрт температурын горимын зөрчил байна: Мах эвдэх цехийн хэм +16°C байсан нь Гаалийн Холбооны нормоос (+12°C) илүү байна (ТР ТС 034/2013 “Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал”-ын тухай техникийн зохицуулалт)
4. Цехүүдэд хэрэглэдэг хайрцаг савыг өнгөөр нь юм уу, өөр ямар нэгэн тэмдэглэлээр хооронд нь ялгаагүй байгаа нь тэдгээрийг зориулалтаар нь ялгахад хүндрэл учруулахаар байна. Мах эвдэх болон нядалгааны цехүүдэд таних тэмдэггүй, ижил төрлийн хайрцагт био хаягдал, мах, махан бүтээгдэхүүн (мах, дайвар бүтээгдэхүүн) хийж байв.
5. Үйлдвэрийн ахуйн хэсэгт барилгын, ахуйн, биохаягдалыг нэг дор хаясан байна.
6. Үйлдвэрийн талбайд мал тээвэрлэх болон бэлэн бүтээгдэхүүн гадагш гаргах замууд хоорондоо огтлолцож байна.
7. Үйлдвэрийн автомашин ариутгах халдваргүйтгэлийн цэг (дезбарьер) хангалтгүй байдалтай байна, тээврийн хэрэгслийн явах эд ангийн халдваргүйтгэлийг шаардлагатай хэмжээнд хийх боломжгүй байна. Дебарьерт ариутгалын бодис байхгүй, бодис шингээгчийн оронд хивс ашигласан байна. Үйлдвэрийн хашаанд нэвтрэх болон бэлэн бүтээгдэхүүн гарах хаалганд ариутгал халдваргүйжүүлэлтийн цэг (Дебарьер) байхгүй байна. Үйлдвэрийн нутаг дэвсгэрт нядалгааны мал ачиж ирсэн тээврийн хэрэгслийн хөдлөх эд ангийг ариутгаж халдваргүйжүүлэх дезбарьер байхгүй байна.
8. Зарим үйлдвэрийн орох хаалганд орчин үеийн эрүүл ахуй ариун цэврийн дезбарьер байрлуулсан боловч түүнд халуун хүйтэн ус өгөх оролт алга бөгөөд хүйтний улиралд хэрхэн ажиллах нь тодорхой бус байна.
9. Хөргүүртэй агуулахын температурын бүртгэл хөтөлдөггүй, махны гүний температурыг хэмждэггүй. Хөргүүрийн горимд хяналт тавьдаггүй байна.
10. Тоног төхөөрөмж, ажлын байранд тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийдэг тухай нотлох баримт үзүүлээгүй (төхөөрөмж, хөргүүртэй агуулахуудаас авсан арчдасын лабароторын шинжилгээний дүнг үзүүлээгүй).
11. Цэвэрлэгээний хэрэгслийг хадгалах зориулалтын өрөө байхгүй, тэдгээрийг үйлдвэрлэлийн байрандаа хадгалдаг байна.
12. Үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашигладаг ундны усны чанар, аюулгүй байдлалд хяналт тавьдаггүй байна.
13. Ариутгал, хортон шавьж, мэрэгчдийн устгалд чанарын хяналт хийсэн тухай нотлох баримт танилцуулаагүй. Бүртгэлийн журнал байхгүй.

14. Мах эвдэх, шулах цехед халуун ус байхгүй байсан. Хутга солих, ариутгах хуваарь байхгүй, ажилчид хутгаа өөрсдөө ариутгадаг байна. Тухайлбал шалгалтын үед нэг ажилтан хутгаа угааж, ариутгасныхаа дараа шууд ажлаа үргэлжлүүлэн ариутгалын бодисыг түүхий эдэд оруулж байв.
15. Зарим мах боловсруулах үйлдвэр мал эмнэлгийн тамгагүй, гарал үүсэл нь тодорхойгүй гулууз мах хүлээн авдаг байна.
16. Хөргүүртэй агуулахад шошгогүй хайрцагтай болон тамгагүй мах, хөлдөөсөн жимс, загас хадгалж байсан нь төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг хамт хадгалахгүй байх зарчмыг зөрчиж байна.
17. Үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн бүртгэх систем нь түүний гарал үүслийг мал бэлтгэн нийлүүлсэн ферм-нийлүүлэгч хүртэл мөшгөх боломжийг олгохгүй байна.
18. Мал эмнэлгийн тамгагүй гулууз махыг мах боловсруулах үйлдвэрт хүлээн авч байна.
19. Хяналтанд хамрагдсан Монголын ихэнхи үйлдвэрүүдийн мэргэжилтнүүд Гаалийн холбооны болон ОХУ-ын хууль дүрмийг бүрэн хэмжээгээр мэдэхгүй байна. Гаалийн холбооны болон ОХУ-ын норматив бичиг баримтууд бүрэн хэмжээгээрээ үйлдвэрүүдэд хүргэгдээгүй байна. Сургалт нь ёс төдий танилцуулах хэмжээнд явагдсан байна.

3.1.4. ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ

ОХУ дулааны аргаар боловсруулсан бэлэн бүтээгдэхүүнд хянан магадлагаа хийхдээ дараах хоёр төрлийн хяналтыг байнга хийж байхыг шаарддаг байна. Дулааны аргаар боловсруулсан бэлэн бүтээгдэхүүнд дараах хяналтыг хийнэ.



ОХУ-ын дотоод хяналтыг бүтээгдэхүүний цувралын дугаар бүрээс дээж авч термостатын шалгалт (дулааны аргын шалгалт) хийхийн зэрэгцээ доорх үзлэг, шалгалтыг хийнэ. Үүнд:

- Бүтээгдэхүүний сав баглаа боодлын (төмөр лааз, шилэн сав, полимер уут) битүүмжийг шалгана.
- Бүтээгдэхүүний pH-ийн үзүүлэлтийг шалгана.
- Микроскопоор харж, бактери тоолно.
- Мэдрэхүйн үзүүлэлтээр шалгана (органолептика).
- Хадгалалтын хугацааг шалгах, ул мөрийг мөшгөх шаардлага гарвал хэрэглэх зорилгоор дээж авч архивд хадгална.

Дотоод хяналтын үнэлгээг "Үйлдвэрийн ариутгалыг тодорхойлох арга" буюу ОХУ-ын ГОСТ 30425-97 –ын дагуу хийнэ. Шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. Үйлдвэрийн ариутгалыг тодорхойлох арга

№	Шалгуур үзүүлэлтүүд (Показатели)	Байх ёстой хэмжээ (Норма)
1	Савны битүүмжлэл Герметичность упаковки	1. Бамбааж (хий) үүсээгүй байх. (без бомбаж) 2. Амсар, ёроол, хажуу болон нүүрэн талд ямар нэгэн гэмтэл байх ёсгүй.

2	pH –ийн үзүүлэлт pH показатель	4,2-оос $\pm$ 0,5-аас илүүгүй байх
3	Микроскопоор харах Микроскопи-рование	Бактерийн нэгж эсийн тоо 10 –аас ихгүй ба тэжээлт орчинд бичил биет үржээгүй байна.
4	Мэдрэхүйн үзүүлэлт Органолиптические показатели	Энэхүү журмын 2 хэсгийн 1 дүгээр хүснэгтэнд заасан үзүүлэлтүүдийг хангасан байна.

Эх сурвалж: ГОСТ 30425-97

Мэдрэхүйн болон физик-химийн үзүүлэлт ГОСТ Р 54033-2010 Махан нөөш. Жигнэсэн мах. Техникийн үзүүлэлт (ГОСТ Р 54033-2010 Консервы мясные. Мясо тушеное. Технические условия)

Хүснэгт 8. Мэдрэхүйн болон физик-химийн үзүүлэлт

Үзүүлэлт	Шинж чанар					
	Үхрийн жигнэсэн мах дээд зэрэглэл	Үхрийн жигнэсэн мах 1-р зэрэглэл	Хонины жигнэсэн мах дээд зэрэглэл	Хонины жигнэсэн мах 1-р зэрэглэл	Адууны жигнэсэн мах дээд зэрэглэл	Адууны жигнэсэн мах 1-р зэрэглэл
Амт, үнэр /Запах и вкус/	Ямар нэг гадны үнэр, амтгүй. Өөрийн өвөрмөц амт, үнэртэй байна.					
Гадаад төрх байдал / Внешний вид/	Бүтээгдэхүүнийг халаасны дараа махны хэрчилтийн жин нь 30 гр-аас багагүй, шөрмөс, бүлх, булчирхай, мөгөөрс, бүдүүн судас зэрэг зүйлгүй. Савнаас нь гаргахад махны хэрчимийн хэрчилтүүд нь хэлбэрээ хадгалсан хэвээрээ байна. 30 граммаас бага жинтэй хэрчимүүд нийт махны 10 %-иас хэтрэхгүй байна.					
Махны төлөв байдал / Консистенция мяса /	Мах нь шүүслэг, хэт чанагдаагүй байх ёстой.					
Шөлний харагдах байдал / Внешний вид бульона /	Шөлийг халаахад шар өнгөөс цайвар бор өнгөтэй болно. Бага зэрэг булингартай өтгөн байж болно.					
Гадны биет Посторонние примеси	Байж болохгүй.					
Мах, өөх тосны нийт эзлэх хэмжээ, % багагүй Массовая доля мяса и жира, %, не менее	58	56	58	56	58	56
Уургийн эзлэх хэмжээ, % багагүй Массовая доля белка, %, не менее	15		15		15	
Өөх тосны агууламжийн эзлэх хэмжээ, % ихгүй Массовая доля жира, %, не более	17		17		17	
Давсны эзлэх хэмжээ, % Массовая доля поваренной соли, %	1.0-1.5					
100 гр бүтээгдэхүүний тэжээллэгийн тухай мэдээлэл						

Өөх тосны хэмжээ, гр-аас ихгүй Жир, г, не более	17	17	17
Уургийн хэмжээ, гр-аас багагүй Белок, г, не менее	15	15	15
Илчлэг, ккал-иас ихгүй Калорийность, ккал, не более	213	213	213

Эх сурвалж: ГОСТ Р 54033-2010

Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатороор дотоод хяналтын лабораторийн үнэлгээгээр чанарын шалгалт давсан цувралын дугаар бүхий бүтээгдэхүүнээс дээж авч, дараах үзүүлэлтээр дүгнэлт гаргуулна. Үүнд:

- Хүнд металл
- Цацраг идэвхит бодис
- Антибиотикийн үлдэгдэл
- Бичил биет

Эдгээр үзүүлэлтүүдийн аюулгүй байдлын хэмжээг Гаалийн холбооны техникийн горим. ТР ТС 021/2011 “Хүнсний аюулгүй байдлын тухай” Хавсралтаар, Гаалийн холбооны техникийн горим. ТР ТС 034/2013 “Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” техникийн зохицуулалтуудад заасан байдаг.

Хүснэгт 9. ТР ТС 021/2011 “Хүнсний аюулгүй байдлын тухай” техникийн зохицуулалт

№	Хүнд металын үлдэгдэл	Зөвшөөрөгдөх хэмжээ мг/кг ихгүй	Тайлбар
1	Хар тугалга	0,5	Мах, махан бүтээгдэхүүн, консерв
2	Хүнцэл	0,1	
3	Кадмий	0,05	
4	Мөнгөн ус	0,03	
5	Цагаан тугалга	200	
6	Хром	0,5	
№	Антибиотикийн үлдэгдэл	Зөвшөөрөгдөх хэмжээ мг/кг ихгүй	Тайлбар
1	Гексахлораны (C ₆ H ₆ Cl ₆)	α - Изомер 53-70 β - Изомер 53-70 γ - Изомер 53-70	Мах болон мах агуулсан бүтээгдэхүүн, дотор эрхтэн, мах болон дотор эрхтнээр хийсэн консерв
2	ДДТ (дихлордифенил трихлорметилметан)	0,1	Мах болон мах агуулсан бүтээгдэхүүн, дотор мах, мах болон дан дотор махаар хийсэн консерв
3	Нитратууд	200	Мах, будаа, ногоотой консерв
4	Нитрозоамины (N-нитрозометиламин НДМ)-нитрозодиэтиламин НДЭА	0,002	Мах болон дотор махтай консерв, дотор махан нухаш
5	Диоксинууд	0,000003 (тосонд шилжүүлснээр)	Үхэр, хонины махан консерв
№	Цацраг идэвхит бодисын үлдэгдэл	Зөвшөөрөгдөх хэмжээ, Бк/кг л (беккерель/кг литр)	Тайлбар
1	Цезийн тодорхой үйл ажиллагаа	200	Мах, махан бүтээгдэхүүн, дотор эрхтэн
2	Стронцийн тодорхой үйл ажиллагаа Бк/кг л	Илрэх ёсгүй	

Эх сурвалж: ТР ТС 021/201, техникийн зохицуулалт

Хүснэгт 10. Гаалийн холбооны техникийн горим. ТР ТС 034/2013, №№-1-2

	Бичил биетний групп	Бактери	Зөвшөөрөгдөх хэмжээ мг/кг ихгүй
1	Спор үүсгэгч мезофильно аэробный болон факультативно анаэробный микроорганизмууд (Bacillus-ийн бүлэг)	Bacillus cereus, Bacillus polymyxa	1 гр (см³) дээжинд илрэх ёсгүй
2	Спор үүсгэгч мезофильно аэробный болон факультативно анаэробный микроорганизмууд (Bacillus-ийн бүлэг)	B.subtilis	1 гр (см³) дээжинд 11 ширхэгээс ихгүй байж болно.
3	Мезофильные колостриды Cl.botulinum эсвэл Cl.perfringens	Cl.botulinum эсвэл Cl.perfringens	1 гр (см³) дээжинд илрэх ёсгүй.
4	Мезофильные колостриды Cl.botulinum эсвэл Cl.perfringens-ээс бусад	Cl.sporogenes, Cl.putrificus, Cl.thermosaccharolyticus	1 гр (см³) дээжинд 1 ширхэгээс ихгүй байж болно.
5	Спор үүсгэгч бус микроорганизмууд буюу сүүний хүчил, хөгц мөөгөнцөр	Streptococcus E.coli, P.vulgaris, Fungus and mould	1 гр (см³) дээжинд илрэх ёсгүй.
6	Спор үүсгэгч термофильный аэробный болон анаэробный, факультативный анаэробный микроорганизмууд	Bac.mesentericus ruber, Bac.asterosporus, S.aureus, Bac.coagulans, Aerothermophilus	Хадгалах хэм нь +20°C С-ээс их байх тохиолдолд 1 гр (см³) дээжинд илрэх ёсгүй
7	Salmonella	Salmonella	25 гр дээжинд илрэх ёсгүй
8	Listeria monocytogenes	Listeria monocytogenes	25 гр дээжинд илрэх ёсгүй

Эх сурвалж: ТР ТС 034/2013-Техникийн зохицуулалт

3.2. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

ОХУ-ын аж ахуйн нэгжтэй дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох гэрээ байгуулахдаа Монгол улсын олон улсын гэрээ болох Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийг²⁶ (Венийн конвенц 1980 оны) баримтлах ба гэрээнд дараах зүйлийг тусгах шаардлагатай.

Хүснэгт 11. Гэрээний нөхцөл, анхаарах зарим асуудал

№	Гэрээнд тусгах зүйл	Тайлбар
1	Барааны үнэ	Барааны үнийг талууд харилцан ашигтай байдлаар тохиролцож, нэгжийн болон нийт үнийг тусгана.
2	Төлбөр тооцоо	Дараах зүйлийг тусгана. Үүнд: ✓ Төлбөр ачилтын өмнө, хойно эсвэл хослуулан хийх эсэх ✓ Төлбөр төлөх хугацаа ✓ Төлбөрийн хэрэгслийг зөв сонгох (валют, бараа, үйлчилгээ гэх мэт) ✓ Төлбөр төлөх хэлбэрээ сонгох (аккредитив, инкасс, нээлттэй данс, шилжүүлэг, эскроу данс)
3	Чанар	✓ Чанарыг ямар үзүүлэлтээр хэмжих ✓ Ямар бичиг баримтаар баталгаажуулах зэргийг тусгана.

²⁶ <https://www.legalinfo.mn/law/details/1220>

4	Тоо хэмжээ	✓ Боломжит тоо хэмжээг урт удаан хугацаанд өсөн нэмэгдэх байдлаар тусгана.
5	Нийлүүлэх газар, хугацаа	✓ “Инкотермс 2010 болон 2020” нөхцөлийн ялгааг ойлгох, ✓ Сонгосон Инкотермсийн нөхцлөөс шалтгаалан барааг нийлүүлэх газар болон хугацаа, түүнчлэн бичиг баримт бүрдүүлэх, зардал болон эрсдэл хуваарилах зэрэг асуудлыг тусгана.
6	2 талын үүрэг, хариуцлага	
7	Маргаан	✓ Маргаан гарсан үед хэрхэн шийдвэрлэх (Харилцан тохиролцож эвлэрэх, арбитр, шүүх) ✓ Аль улсын арбитр сонгох (ОХУ, Монгол улсын үндэсний болон олон улсын арбитр) зэргийг тусгана.
8	Давагдашгүй хүчин зүйл	✓ Ямар нөхцөлийг давагдашгүй хүчин зүйл гэж үзэх ✓ Давагдашгүй хүчин зүйл гарсан тохиолдолд хэн баталгаажуулах зэргийг тусгана.
9	Бусад	✓ Нэмэлт өөрчлөлтийг ямар тохиолдолд оруулж болох ✓ Ямар хэл дээр хэдэн хувь үйлдэгдсэн ч бүгд хуулийн хүчин төгөлдөр эсэх ✓ Гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий этгээд ✓ Төлбөр тооцоо хийх банкны мэдээлэл зэрэг шаардлагатай гэж үзсэн зүйлийг оруулна.

Дулааны аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүний худалдаа арилжааг хийж эхлэхээс өмнө экспортлогч, импортлогч талууд зарим нэг бэлтгэл ажлуудыг хийсэн байх шаардлагатай.

Тохирлын гэрчилгээ. Экспортлогч нь экспортлох гэж байгаа **жигнэсэн махны төрөл тус бүрээр** Тохирлын гэрчилгээг авах бөгөөд хугацаа нь 1-3 жил байж болно. Энэ гэрчилгээ импортлогч барааны гаалийн бүрдүүлэлт хийхэд заавал шаардагдах бичиг баримт болно. Тохирлын гэрчилгээний загварыг Хавсралт №12-т харуулав.

Импортын зөвшөөрөл. Импортлогч тал барааг импортлохоос өмнө тухайн бараанд ОХУ-ын/ЕАЭЗХ-ын зах зээд борлуулах Тохирлын деклараци (Декларация о соответствии) Хавсралт №30 авсан байна.

Тохирлын деклараци нь тухайн бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ын техникийн зохицуулалтын ТР ТС 034/2013 “О безопасности мяса и мясной продукции” Хавсралт №22, Хавсралт №21-т заасан дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүний бичил биетний норматив үзүүлэлтүүдийг, ТР ТС 021/2011 “О безопасности пищевой продукции”, Хавсралт №20-т заасан дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүний эрүүл ахуйн норматив үзүүлэлтүүдийг хангасан гэдгийг нотлох баримт юм. Өөрөөр хэлбэл “Тохирлын декларация” нь тухайн бүтээгдэхүүн холбооны орнууд болон ОХУ-ын зүгээс шаардаж байгаа хүнсний аюулгүй байдал, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна гэдгийг гэрчилж байгаа юм.

Импортлогч тал жигнэсэн махан бүтээгдэхүүн импортлохоос өмнө өөрийн оршин байгаа орон нутгийн Хөдөө аж ахуйн хяналтын албанаас (Россельхознадзор) жигнэсэн мах импортлох тухай Импортын зөвшөөрөл (Разрешение на ввоз) авсан байна.

Харин жигнэсэн мах экспортлох гэж байгаа компани нь ОХУ-ын Хөдөө аж ахуйн хяналтын албанаас (Россельхознадзор) гаргасан “Гуравдагч орны жагсаалтанд” орсон байх шаардлагатай. Импортлогч тал Импортын зөвшөөрөл аваагүй бол тухайн барааг ОХУ-ын хилээр нэвтрүүлэхгүй.

Гэрээнд тусгах нэмэлт бичиг баримт. Импортлогч тал импортын гаалийн бүрдүүлэлт хийх мэдүүлэгчээс жигнэсэн мах импортлох үед ямар, ямар нэмэлт бичиг баримт хэрэгтэй

болохыг заавал урьдчилан тодруулж энэ тухай экспортлогч Монгол талын түншдээ мэдэгдэж эдгээр бичиг баримтыг Монгол талаас бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтанд оруулах заалтыг гэрээнд тусгах хэрэгтэй. Тухайлбал, Оросын талаас импортын бүрдүүлэлт хийх гэж байгаа мэдүүлэгч экспортлогч талаас дараах бичиг баримт бүрдүүлэхийг хүсч байсан. Үүнд:

- Үнийн тухай хэлцэл буюу үнийн санал тавьсан тухай албан тоот, оферт гэх мэт, (энэ мэдээллийг мэдүүлэгч импортлох барааны хилийн үнийг тодорхойлоход ашигладаг, учир нь ОХУ-ын гааль тухайн бараанд жишиг үнэ тогтоосон байдаг бөгөөд импортлохоор мэдүүлж байгаа бараа нь тухайн барааны жишиг үнээс хэт хямд, хэт үнэтэй эсэхэд хяналт тавьдаг.)
- Тухайн бүтээгдэхүүнд ГМО (Хувиргасан амьд организм), БАД (биологийн идэвхтэй нэмэлт) орсон эсэх тухай тодорхойлолт
- Импортын бараа ачуулсан байршлаас Оросын хил хүртэл тээврийн зардлын тухай тээвэрлэгч байгууллагын тодорхойлолт (энэ мэдээллийг мэдүүлэгч барааны хилийн үнийг тодорхойлох, улмаар гаальд төлөх гаалийн татвар, НӨАТ-ын хэмжээг тооцоход ашигладаг)
- Тээвэрлэгчтэй хийсэн гэрээний хуулбар (барааны хилийн үнийг тооцоход хэрэг болдог, өөрөөр хэлбэл тээврийн зардлыг баталгаажуулж байна гэсэн үг)

Барааны шошгонд нэмэлт мэдээлэл оруулах эсэх. Гадаад худалдаанд оролцогч талууд барааны сав баглаа боодлын төрөл, нэгж бүтээгдэхүүний жин, шошгонд оруулах нэмэлт мэдээлэл, тээвэрлэлтийн нэгж сав баглаа боодолд савлах барааны тоо хэмжээ, барааг зориулалтын поддон дээр ачих эсэх талаар урьдчилан тохиролцох хэрэгтэй. Барааг поддон дээр ачихад оросын гааль поддоны гаалийн бүрдүүлэлт хийхийг шаарддаг тул бүрдүүлэлтийн бичиг баримт үйлдэх нэмэлт зардал гарахаас гадна поддоны ургамал хорио цээрийн гэрчилгээ, поддоныг буцаах эсэх, түүний үнэ хэд болох зэрэг асуудал үүсдэгийг анхаарах хэрэгтэй.

3.3. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Гэрээг хэрэгжүүлэх үйл явц нь тээвэрлэлтийг үр ашигтай зохион байгуулах, барааг гаалийн хилээр нэвтрүүлэх, төлбөр төлөх хүлээн авах процесстой нягт холбоотой бөгөөд энэ үйл явц гэрээнд заасны дагуу амжилттай дууссанаар гэрээг хэрэгжлээ гэж үздэг.

3.3.1. ТӨЛБӨР ТООЦОО

Экспортлогчийн төлбөр хүлээн авах банк нь импортлогчийн банктай шууд харилцаатай (дундын банк байхгүй гэсэн үг) бол төлбөр тооцоо хурдан орж ирнэ. Тухайлбал манай ихэнх банкууд ОХУ-ын Сбербанктай шууд харилцдаг. Гадаад төлбөр тооцоо хүлээн авах банкны мэдээллийг харилцагч банкнаасаа албан ёсоор авах нь зүйтэй. Сбербанкаар хийсэн гадаад гүйлгээ 1-2 хоногт таны дансанд орно.

Олон улсын санхүүгийн зах зээлд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан одоогийн байдлаар төлбөрийн валютаар оросын рублийг сонгох нь зүйтэй. Харин ханшийн хэлбэлзлийн тухай заалтыг гэрээнд заах нь гэрээний талуудын эрх ашигт нийцнэ.

Оросын ихэнх компани төлбөрийн аккредитив нөхцөлийг хүлээн авах дургүй байдаг тул гэрээнд урьдчилгаа төлбөрийн асуудлыг тусгах хэрэгтэй. Урьдчилгаа нь нэг талаас гэрээний баталгаа, хоёрдугаарт урьдчилгаа төлбөрөөр бүтээгдэхүүний сав баглаа боодол, зарим түүхий эд худалдан авах гэх мэт эргэлтийн хөрөнгө байдлаар ашиглагдаж болно. Төлбөрийн асуудлыг бараа нийлүүлэх графиктай уялдуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл

тухайн жилд юм уу тодорхой хугацааны дотор нийлүүлэх барааны урьдчилгаа, үлдэгдэл төлбөр зэргийг хэрхэн хийх талаар төлбөрийн график үйлдэх нь зүйтэй.

Төлбөрийн аккредитив нөхцлөөр бараа нийлүүлэх бол ямар, ямар баримтын эсрэг төлбөр хийх тухай нөхцлөө маш нарийн тохирч экспортлогчийн зүгээс эдгээр баримтыг ямар ч алдаагүй мадаггүй үйлдэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

3.3.2. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОХУ-руу экспортлох барааны тээвэрлэлтийг төмөр замаар, автомашинаар гэсэн хоёр замаар хийж болно. Төмөр замын тээвэрлэлт нь их хэмжээний бүтээгдэхүүн (нэг удаагийн ачилтаар 130 орчим тонн бүтээгдэхүүн ачна) экспортлоход ашигтай боловч сүүлийн үед төмөр замаар температурын горим бүхий ачаа тээвэрлэх вагоны иж бүрдлийн (мех. секц буюу хөргөлтийн нэг вагон, бараа ачих дөрвөн вагоноос бүрдсэн тээврийн цуваа) олдоц ховор, нөгөө талаар вагон захиалах хүнд суртлаас болж төмөр замаар мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэхээ больсон байна.

Тээврийн хэрэгсэл жолоочид тавих шаардлага

- ОХУ-д ачаа ачсан тээврийн хэрэгслийн нийт жин 40.0 тонноос дээшгүй байх тухай зохицуулалт байдаг тул бараа экспортлогч болон тээвэрлэгч талууд тээврийн хэрэгслийн өөрийн жин болон ачааны жинг тооцох хэрэгтэй.
- Монголоос ОХУ-руу тээвэр хийж байгаа тээврийн хэрэгслийн жин болон тээврийн хэрэгслийн жолоочийн ажил амралтын бүртгэлийн хуудасны (диск тахографика) эхний шалгалтыг Гусино-Озерскийн авто хэрэгслийн хяналтын цэгт шалгадаг тул жолооч диск тахографикийн дугуйг хөтөлж сурсан байх шаардлагатай. Тээврийн хэрэгслийн жин хэтэрсэн, тахографикийн диск бөглөөгүй тохиолдолд их хэмжээний торгууль төлөх ба барааг хулээн авах эцсийн цэг хүртэл тээвэрлэх асуудалд эрсдэл үүснэ.
- Тээврийн хэрэгсэлд ачааг ачихдаа машины тэнхлэг тус бүрт ногдох даацыг нарийн тооцох хэрэгтэй. Тээврийн хэрэгслийн аль нэг тэнхлэгийн даац хэтэрсэн тохиолдолд тээврийн хэрэгслийг ОХУ-ын гаалиар нэвтрүүлдэггүй.
- Тээвэрлэлтийг техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй, техникийн хяналтын үзлэг тооллогод хамрагдсан, хөдөлгөөний болон экологийн аюулгүйн шаардлагуудыг бүрэн хангасан, тусгай зориулалтын битүү тэвш бүхээг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх,
- Хүнсний бүтээгдэхүүнийг бохирдуулах, эвгүй үнэр оруулах, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис зэрэг ачаатай хольж тээвэрлэхийг хориглоно.
- Бараа ачихаас өмнө тээврийн хэрэгслийг угааж ариутгал, халдваргүйтгэл хийсэн байна.
- Тээвэрлэлт, ачиж буулгах явцад ачааны бүрэн бүтэн байдал, чанарыг алдагдуулахгүйн тулд стандартын баглаа боодол, сав хайрцаг, шошго, хаяг битүүмжлэл зэргийг хангасан барааг тээвэрлэлтэд хүлээлгэж өгөх, тээвэрлэгч хүлээн авах.
- Хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн өөр нөхцөл шаарддаг бусад ачаатай хольж ачих, тээвэрлэхгүй байх.
- Хүнсний бүтээгдэхүүнийг гаднах орчны нөлөөллөөс /цас, бороо, чийг, нар, салхи, шороо, тоос гэх мэт/ хамгаалах тусгай зориулалтын битүү тэвш бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

- Хана, дээвэр, суурь хэсэг нь дулаан тусгаарлагч бүхий битүү тэвш, бүхээгтэй, эсвэл эдгээр нь хөргөх юм уу хөлдөөх нэмэгдэл төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- Тээврийн хэрэгслийн жолооч нь тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг эрхлэх тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байна.
- Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, түүний нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслийн техникийн бүрэн байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангана.
- Жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцастай байна.
- Тээвэрлэлтийн болон ачих, буулгах ажиллагааны явцад ачааны физик, химийн болон хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүй, механик гэмтэл учруулахгүй, чанарыг хадгалж хүргэнэ.
- Ачааны баглаа боодол, сав бэхэлгээ битүүмжлэл /лац ломбо/ зэргийг холбогдох стандарт, ачаа тус бүрийн тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бүрдүүлж тээвэрлүүлнэ.

Улсын хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгийн бүрдүүлэлт бэлэн болсоны дараа томилогдсон гаалийн байцаагчийн хяналтын дор экспортын барааг тээврийн хэрэгсэлд ачна. Ачилтын дараа гаалийн байцаагч холбогдох бичиг баримтад гарын үсэг зурж өөрийн тамгыг дарж, тээврийн хэрэгсэлд лац ломбоо зүүж ачаа тээврийн падан дээр дугаарыг нь бичнэ.

Бараа ачилтын үед МХЕГ-ын Хилийн хяналтын газрын байцаагч “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас”-ны дагуу бичиг баримтын болон биет шалгалт хийж экспортыг баталгаажуулан хилийн боомт дахь хяналтын албанд “Экспортын мэдэгдэл” бичиж, тээврийн хэрэгсэлд лац ломбоо зүүж ачаа тээврийн падан дээр дугаарыг нь бичнэ. Мөн “Мал эмнэлгийн гэрчилгээ”-н дээр өөрийн тамгыг дарж гарын үсэг зурна. “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас”-ны загварыг Хавсралт № 6 харуулав.

3.4. САВ БАГЛАА БООДОЛ, ШОШГО

Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч талууд барааны сав баглаа боодлын төрөл, нэгж бүтээгдэхүүний жин, шошгонд оруулах нэмэлт мэдээлэл, тээвэрлэлтийн нэгж сав баглаа боодолд савлах барааны тоо хэмжээ, барааг зориулалтын поддон дээр ачих эсэх талаар урьдчилан тохиролцох хэрэгтэй. Барааг поддон дээр ачихад оросын гааль поддоны гаалийн бүрдүүлэлт хийхийг шаарддаг тул бүрдүүлэлтийн бичиг баримт үйлдэх нэмэлт зардал гарахаас гадна поддоны ургамал хорио цээрийн гэрчилгээ, поддоныг буцаах эсэх, түүний үнэ хэд болох зэрэг асуудал үүсдэгийг анхаарах хэрэгтэй.

3.4.1. САВ, БАГЛАА БООДОЛ, ШОШГОЛОЛТОД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Хүнсний сав баглаа боодол нь зориулалтын, хүнсний бүтээгдэхүүнд үл шилжих/нэвчих, бат, бөх, бохирдлоос бүрэн хэмжээгээр хамгаалсан, түгээлтийн явцад учирч болох механик, хими, дулааны ачааллыг даахуйц байна.
- Сав, баглаа боодлыг бохирдохоос хамгаалсан нөхцөлд хадгална.
- Шошгололт нь тухайн үед мөрдөгдөж байгаа, хууль, стандартын шаардлагуудыг хангасан байна.

ОХУ-ын зах зээлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, тээврийн сав баглаа боодол дээрхи мэдээллийг Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 022/2011-д заасан шаардлагын дагуу бичсэн байх хэрэгтэй. Эдгээр мэдээллийг орос хэлээр бичих ба хэрэв Евразийн/Гаалийн холбооны гишүүн орнуудын холбогдох хууль тогтоомжинд шошгоны мэдээлэл эдгээр импортлогч улсын албан ёсны хэл дээр бичигдэх тухай заалт байгаа бол тэр хэлээр хөрвүүлэн бичих хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл Бүгд Найрамдах Казах Улсын холбогдох хуулинд энэ улсын нутаг дэвсгэрт борлуулах хүнсний барааны шошго казах хэлээр бичигдсэн байх ёстой гэсэн заалт байвал шошгон дээрхи мэдээллийг орос хэлээр бичихээс гадна казах хэлээр бичсэн байна гэсэн үг.

Хүнсний бүтээгдэхүүний шошгон дээр бүтээгдэхүүний тухай холбогдох мэдээллийг оруулахаас гадна түүний сав баглаа боодлын бүтэц ямар болох, түүнийг ямар материалаар хийсэн, холбооны орнуудын нутаг дэвсгэр дээр борлуулалтанд орж болох тухай тэмдэг, сав баглаа боодлыг дахин эргэлтэнд оруулж болох эсэх тухай тэмдэг байрлуулна.

Үүнээс гадна хүнсний бүтээгдэхүүнийг ОХУ/ЕАЭЗХ-ын зах зээлд борлуулахаас өмнө түүний сав, таглаанд “Тохирлын гэрчилгээ” авдаг болсон тул сав болон таглааны ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүд нь “Сав баглаа боодлын аюулгүй байдлын тухай” Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 005/2011-ыг хангасан байх хэрэгтэй.

Энэхүү зохицуулалт нь тухайн бүтээгдэхүүний гарал үүслээс үл хамаааран Гаалийн холбооны нутаг дэвсгэр дээр борлуулагдаж байгаа бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодолд нэгэн адил хамаарна.

3.4.2. САВ БАГЛАА БООДЛЫН СТАНДАРТ, ТУСГАЙ ШААРДЛАГА

Хүнсний бүтээгдэхүүн савлах сав, тагны ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал нь “Сав баглаа боодлын аюулгүй байдлын тухай” Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 005/2011-д нийцэж байх ёстой бөгөөд энэ зохицуулалтанд хүнсний бүтээгдэхүүн савлах савны материал нь:

- Металл, түүний хайлш буюу бидний хэлж сурснаар бол лааз
- Хуванцар нийлэг материал
- Цаас ба картон
- Шил
- Мод
- Хосолмол материал
- Даавуу, таар шуудай
- Шаазан, ваар/керамик байж болно гэж заажээ.

Мөн хүнсний бүтээгдэхүүн савлах савны тагны материал нь:

- Төмөр
- Хальс
- Хуванцар нийлэг материал
- Хосолмол материал
- Картон байж болно гэжээ.

Өөрөөр хэлбэл ОХУ-д экспортлох дулааны аргаар боловсруулсан мах бүтээгдэхүүн нь металл түүний хайлш оролцсон лааз, шилэн сав, эсвэл хосолмол хуванцар нийлэг материалан уутанд савласан байж болно. Шилэн лаазны таглаа нь металл материалтай

байж болно.

Тайлбар: Хуванцар нийлэг материалууд гэдэгт өндөр, нам нягттай Полиэтилен (PE), Полистирол (PS), Полипропилен (PP), Полиэтилентерефталат (PET), Полиамид (PA), Поливинилединхлорид (PVDC) гэх зэрэг материалууд ордог.

Хосолмол материал нь тусгай зорилгоор хослуулан гаргасан сав, боодлын материал бөгөөд түүнийг илүү сайн шинж чанартай болгодог. Хосолмол материалыг 3 бүлэгт хуваадаг байна.

- Төрөл бүрийн полимер хальс хосолсон олон давхаргат материал,
- Полимерийн хальсыг хөнгөн цагааны ялтастай хослуулсан олон давхаргат материал
- Полимерийн хальсыг цаас, картонтой хослуулсан олон давхаргат материал

Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүнийг шууд лааз юм уу нийлэг уутанд савлаж болохгүй. Ер нь хүнсний бүтээгдэхүүний савлах металл савны дотор тал болон гагнуур явсан хэсгээр тусгай түрхэц түрхдэг. Түрхэцээр бүрхсэн давхаргыг хүнстэй шууд харьцах хэсэг давхарга гэдэг.

Полимер уут нь хэд, хэдэн давхар нийлэг эдээс бүрдэх бөгөөд давхар бүр нь өөр өөрийн зориулалттай байдаг. Тухайлбал 4 давхар үетэй полимер уутны хамгийн гадна талын давхарга үе нь шошгоны мэдээлэл бичих зориулалтын материалаас бүрдсэн, хоёр дахь үе нь гэрэл, дулаанаас хамгаалсан, гурав дахь үе нь уутны бат бэх чанарыг хангах, дөрөв дэх үе нь хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцах хэсэг юм.

ОХУ-д экспортлох дулааны аргаар боловсруулсан мах бүтээгдэхүүн экспортлохоос өмнө тухайн бүтээгдэхүүн болон түүний сав баглаа боодолд тохирлын гэрчилгээ заавал авах хэрэгтэй гэдгийн дахин дурдъя. Тухайн сав баглаа боодлын материал нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- ариун цэвэр, эрүүл ахуй шалгуур хэрхэн хангаж байгаа
- механик нөлөөллийн шалгуур
- химийн орчинд тэсвэртэй байдлын шалгуур
- битүүмжлэлийн найдвартай байдал зэрэг шаардлагуудыг цогцоор нь хангасан тохиолдолд л тухайн сав баглаа боодлыг аюулгүй гэж үздэг байна.

Сав баглаа боодлын хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцдаг хэсгийн ариун цэвэр-эрүүл ахуй байдалд тавигдах шаардлагыг дээр дурдсан Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 005/2011 –ийн Хавсралт №19-д, ариун цэвэр-химийн үзүүлэлтийг шалгах “загвар орчны” нөхцөлүүдийг Хавсралт №19-т үзүүлсэн ба сав баглаа боодлын механик нөлөөллийн шалгуур үзүүлэлт болон химийн орчинд тэсвэртэй байх аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг дээрхи техникийн зохицуулалтын 6.1-6.8 зүйлд заасан байна. Үүнээс экспортлогчдын өргөн хэрэглэж байгаа төмөр болон шилэн сав, нийлэг уутан савлагаанд тавигдах механик нөлөөллийн шалгуур үзүүлэлт болон химийн орчинд тэсвэртэй байдлын үзүүлэлтүүдийг нарийвчлан авч үзье.

Төмөр лааз / упаковка металлическая

- лаазан дотор илүүдэл даралт үүссэн үед бүтээгдэхүүний битүүмжлэл алдагдахгүй байх
- лаазны босоо тэнхлэгийн дагуу үзүүлэх шахалтыг тэсвэрлэх чадвартай байх
- лаазны дотор талын түрхэц савласан бүтээгдэхүүнд уусахгүй/нэвчихгүй, загвар орчинд турших ариутгал/стерилизац, пастеризацад тэсвэртэй байх
- лааз, болон лаазны дотор талын түрхэц зэврэхгүй байх ёстой.

Шилэн сав / упаковка стеклянная

- шилний үндсэн үзүүлэлт, шилэн савыг ашиглах зорилгоос хамааран дотоод гидростатик даралтыг тэсвэрлэх ёстой
- орчны температур буурахад гэмтэхгүй, хагарахгүй байх
- шилний босоо тэнхлэгийн дагуу үзүүлэх шахалтыг тэсвэрлэх чадвартай байх
- хүнсний бүтээгдэхүүний савлагаанд ашиглах шилний усанд тэсвэртэй байх үзүүлэлт 3/98 ангиллаас дээгүүр байх
- хүнсний хүчилд хүчилд тэсвэртэй байх
- согтууруулах ундаа болон хүүхдийн хоол савлахад дахин ашиглах боломжгүй байх.

Нийлэг уут / упаковка полимерная

- савлагааны битүүмжлэлийг хангаж байх
- өндрөөс унагахад (хэд хэдэн удаа) гэмтэхгүй, задрахгүй байх
- босоо тэнхлэгийн дагуу үзүүлэх шахалтыг тэсвэрлэх чадвартай байх
- халуун ус, халуунд өртөх үед хэлбэрээ өөрчлөхгүй/деформацад орохгүй, задрахгүй байх
- сав баглаа боодлын бариул нь тогтоосон ачааллыг даах чадвартай байх
- савлагааны наалттай хэсгээр ус нэвтрэхгүй, битүүмжлэл сайн байх
- уутыг сунгах үед тогтоосон статик ачааллыг даах чадвартай байх
- дотор талын хүнстэй харьцах давхарга нь савласан бүтээгдэхүүний нөлөөнд тэсвэртэй, түүнд нэвчихгүй байх.

Хүснэгт 12. Шил, шаазан, фаянс, эдгээрээс гаргаж авсан сав болон керамик эдлэлээс ялгарах хар туглага, кадмийн эрүүл ахуйн норматив үзүүлэлт

Савлагааны хэмжээ	Хянах үзүүлэлт	Хэмжих нэгж	ДКМ
Савлагаа 1,1 литр хүртэл	Кадмий	мг/л	0,5
	Свинец	мг/л	2,0
Савлагаа 1,1 литрээс их	Кадмий	мг/л	0,5
	Свинец	мг/л	2,0

Хүснэгт 13. Сав болон таг үйлдвэрлэхэд ашигладаг метал ба хайлшнаас гаргах бодисын аюулгүй байдал эрүүл ахуй, эрүүл ахуйн норматив үзүүлэлтүүд

Сав болон тагны материалын нэр	Хянах үзүүлэлтүүд	ДКМ, мг/л	Ундны усан дахь ПДК, мг/л	Аюулгүй байдлын ангилал
1	2	3	4	5
1.Алюминий первичный				
особой чистоты	Алюминий (Al)	0,500	--	2
высокой чистоты	Алюминий (Al)	0,500	--	2
	Железо (Fe)	0,300	--	--
	Кремний (Si)	--	10,000	2
	Медь (Cu)	1,000	--	3
технической чистоты	Алюминий (Al)	0,500	--	2
	Железо (Fe)	0,300	--	--
	Кремний (Si)	--	10,000	2
	Медь (Cu)	1,000	--	3

	Цинк (Zn)	1,000	--	3
	Титан (Ti)	0,100	--	3
1	2	3	4	5
2.Сплавы алюминия:				
Деформируемые	Алюминий (Al)	0,500	--	2
	Марганец (Mn)	0,100	--	3
	Железо (Fe)	0,300	--	--
	Медь (Cu)	1,000	--	3
	Цинк (Zn)	1,000	--	3
	Титан (Ti)	0,100	--	3
	Ванадий (V)	0,100	--	3
Литейные	Алюминий (Al)	0,500	--	2
	Медь (Cu)	1,000	--	3
	Кремний (Si)	--	10,000	2
	Марганец (Mn)	0,100	--	3
	Цинк (Zn)	1,000	--	3
	Титан (Ti)	0,100	--	3

3.4.3 ШОШГО, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, КОДЧЛОЛ

Оросын холбооны улсад экспортлох дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хаяг, шошгыг Гаалийн холбооны техникийн зохицуулалт ТР ТС 022/2011 “Хүнсний бүтээгдэхүүний шошгололт”-д заасны дагуу хийнэ.

Энэхүү техникийн зохицуулалтын 4 дүгээр хэсэгт (Статья 4) хүнсний бүтээгдэхүүний шошгонд бичигдэх мэдээллүүдийг заасан бөгөөд түүний 4.1 хэсэгт **савлагаатай** хүнсний бүтээгдэхүүний шошгонд бичигдэх мэдээллүүдийг заасан байна. Үүнд:

- 1) хүнсний бүтээгдэхүүний нэр
- 2) хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага
- 3) хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ (жин)
- 4) хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо
- 5) хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах хугацаа
- 6) үйлдвэрлэгчээс тодорхойлсон хадгалах нөхцөл. Бүтээгдэхүүнийг задалсан/онгойлгосон тохиолдолд хэрхэн хадгалах тухай нөхцөлийг зааж өгнө (жишээ нь уутыг задалснаас хойш хугацаанд цаг/өдөр тийм нөхцөлд (хөргөгчинд) хадгална гэх)
- 7) хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нэр, албан ёсны хаяг (хуулийн эдгээдийн гэрчилгээнд бичигдсэн хаяг), импортлогчийн нэр, албан ёсны хаяг
- 8) дээрх дурьдсан техникийн зохицуулалтын 4.9-д заасны дагуу хүнсний бүтээгдэхүүний 100 грамм дахь тэжээллэгийн тухай мэдээллийг шошгонд бичнэ. Энэ нь:

- Тэжээллэг байдалккал.к/Дж
- Уураг/Белок грамм эсвэл %
- Өөх тос/Жир грамм эсвэл %
- Нүүрс ус/Углеводы/ грамм/%
- Витамин /Витаминымиллиграмм эсвэл микрограмм
- Эрдэс бодис/Минералымиллиграмм эсвэл микрограмм

Тайлбар: Тухайн бүтээгдэхүүнд агуулагдах витамин, эрдэс бодис нь насанд хүрсэн хүний өдөрт хэрэглэх нормын 5 хувиас их бол эдгээр үзүүлэлтүүдийг шошгонд бичнэ. /Витамины хэрэгцээг энэ техникийн зохицуулалтын Хавсралт 2-т заасан байгаа/

9) Хэрэглэх заавар

10) хүнсний бүтээгдэхүүн Хувиргасан амьд организм (ГМО) агуулж байгаа эсэх тухай мэдээлэл

11) Гаалийн холбооны нутаг дэвсгэрт зах зээлийн эргэлтэнд оруулж болох тухай нэгдсэн ЕАС тэмдэг

12) Сав баглаа боодлын бүтцийн тухай тэмдэглэл

13) Үйлдвэрлэсэн орон, үйлдвэрлэгч, бүтээгдэхүүний тухай мэдээллийг агуулсан зураасан код буюу бар кодыг бичнэ.

Шошгоны мэдээлэл нь орос хэлээр бичигдсэн байх ёстой ба гаалийн холбооны гишүүн орнуудын холбогдох хууль тогтоомжинд шошгоны мэдээлэл эдгээр улсын албан ёсны хэл дээр бичигдэх тухай заалт байгаа бол тэр хэлээр хөрвүүлэн бичих ёстой.

4. ОХУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ЭКСПОРТЛОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, ҮЙЛ ЯВЦ

ОХУ-ын зах зээлд мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох үйл явцын дүн шинжилгээг НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын ВРА (Business Process Analysis)²⁷ загварын дагуу хийж дараах Хүснэгт болон Зурагт харуулав.

Хүснэгт 14. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дараалал /20 тонн/

Экспортлогч	Үйл ажиллагааны дараалал		Байгууллагууд
	1.	Загварын дээжинд дүгнэлт гаргуулах	МЭАЦЛаборатори
	2.	Эрүүл ахуйн гэрчилгээ	МХЕГ
	3.	Тохирлын гэрчилгээ авах	СХЗГ
	4.	Гарал үүслийн гэрчилгээ авах	МУХАҮТ
	5.	Ачааны манифест Тээврийн бичиг баримт	Тээврийн байгууллага Гаалийн зуучлагч байгууллага
	6.	Гаалийн талбай дахь мэргэжлийн хяналт	НМХГ
	7.	Гаалийн бүрдүүлэлт: -гаальд мэдүүлэх -Бичиг баримтаа шалгуулах	Гааль
	8.	Биет шалгалт хийлгэх	Гааль


Хүснэгт 15. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах зарцуулах цаг хугацаа, зардал

д/д	Үйл ажиллагаа	Хугацаа /өдрөөр/	Зардал /төгрөгөөр/
1.	Загварын дээжинд өгч дүгнэлт гаргуулах	Хамруулдаг 3- 5 хоног /ажлын /	Хариунаас шалтгаална /700000 төгрөг/
2.	Тохирлын гэрчилгээ авах	1цаг	51370 төгрөг /1кг-2 төгрөг/
3.	Гарал үүслийн гэрчилгээ авах	1 цаг	40000-45000 төгрөг
4.	Мал эмнэлгийн арүүл ахуйн гэрчилгээ	Хуулийн хугацаа 14 хоног 2-3 хоногт гардаг	Нэг хувь гэрчилгээ 10000 төгрөг
5.	Гаалийн бүрдүүлэлт хийлгэх: -Гаальд мэдүүлэх -Үнэлгээ хийлгэх	1 өдөр	- Гаалийн мэдүүлэг 1200 төгрөг, 1000 ломбо

²⁷ <http://tf.unece.org/contents/bpa-methodology-analyse-processes.htm>


	-Бичиг баримтыг хянах -Татвар төлөх		- Гаальд мэдүүлэх 10000 төгрөг - Хураамж 1машин 7000 төгрөг
6.	-Гаалийн биет үзлэгт орох: -Бодит шалгалтанд хамрагдах	3-5 цаг	Төлбөрт үйлчилгээ ²⁸
7.	Тээвэрлэлт	2-3 өдөр	Дунджаар 700000-750000 төгрөг

Зураг 6. ОХУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дарааллын цаг хугацаа, зардлын диаграмм



Зураг 7. ОХУ-ын зах зээлд үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай гэрчилгээ зөвшөөрөл авах үйл явц, дэс дарааллын зураглал

²⁸ Гаалийн захиалга дуудлагаар үйлчилсэн үйлчилгээний хураамж: Махны экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийхэд аж ахуйн нэгжийн хүсэлтээр тэдний байр, агуулахад гаалийн хяналт тавьж эхлэн, өөрөөр хэлбэл савлах үеэс нь хяналтаа тавьдаг. Энэ тохиолдолд уг байр агуулах нь “Гаалийн хяналтын түр бүс”-д тооцогдоно. Үйлчилгээний хураамжийг захиалгаар үйлчлэхэд (гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж дээр нэмж тооцно.) хэмээн нэрлэн 1 цагийн хураамж: -ажлын өдөрт 4000 төг; ажлын бус цаг, амралт, баярын өдрүүдэд 8000 төгрөг байхаар журамласан.



4.1. ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ

4.1.1. МАЛ ЭМНЭЛЭГ, ХОРИО ЦЭЭРИЙН ГЭРЧИЛГЭЭ

МХЕГ-т мах экспортлоход хяналт тавих байцаагч томилуулах тухай болон экспортын бүтээгдэхүүний дээжинд шинжилгээ хийлгүүлэх хүсэлт бүхий албан бичиг өгнө. Албан бичигт дараах мэдээлэл бичиг баримт дагалдана. Үүнд:

- Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Худалдах, худалдан авах гэрээ, түүнтэй адилтгах баримт бичиг (Орос, англи хэлээр бичигдсэнээс бусад тохиолдолд монгол хэл дээр баалгаат орчуулгаар орчуулсан байх)
- Стратегийн хүнс экспортлох бол (Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан экспортлох тоо, хэмжээ /квот)
- Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээтэй, гэрчилгээ олгох тухай албан бичиг (Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас)
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ (Мал эмнэлгийн ерөнхий газар)
- Сав баглаа, боодлын мэдээлэл (тоо хэмжээ) Англи хэлээр
- Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн
- Мах, махан бүтээгдэхүүн гуравдагч улсад экспортлох бол ОХУ болон БНХАУ-аас дамжуулан тээвэрлэх зөвшөөрлийн хуулбар

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт (анх удаа экспорт эхэлж байгаа бол)
- ОХУ болон БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох бол тухайн улсад бүртгэгдсэн бүртгэлийн хуулбар /нэг удаа өгөх/

Лабораторийн шинжилгээ хийлгэх экспортлогч компани өөрийн орны эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторт гаалийн холбооны орнуудын техникийн зохиулалтуудад заасан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдээр физик-хими, микробиолог, үлдэгдэл, хүндметалл, цацрагийн шинжилгээ хийлгэдэг бөгөөд энэ шинжилгээний үр дүнг харгалзан Мэргэжлийн хяналтын ерөнхий газар “Мал эмнэлгийн гэрчилгээ” (Гаалийн холбооны орнуудад нөөшилсөн бүтээгдэхүүн импортлоход олгодог Форма 26 буюу Ветеринарный сертификат на экспортируемые на таможенную территорию Евразийского экономического союза консервы, колбасы и другие виды готовых мясных изделий), Стандарт хэмжил зүйн төв “Тохирлын гэрчилгээ” олгодог бөгөөд эдгээр баримт бичиг гаалийн бусад бичиг баримтын хамт импортлогч талд очдог. Эдгээр бичиг баримтуудын хуулбарыг Хавсралт №29-31 харна уу.

МХЕГ-ын томилсон байцаагчийг үйлдвэр дээр авч ирэх ба байцаагч махнаас түүврийн аргаар дээж авч бүтээгдэхүүнд ямар ямар үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгүүлэх тухай мэдэгдэл бичиж дээжийн хамт Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторт хүргэж өгнө. УМЭАЦЭЛ-ын хүлээн авахын эмч дээжийг хүлээн авсан тухай тусгай журналд тэмдэгдэл хийж дээжний код болон тус лабораторт хийлгэсэн шинжилгээний төлбөрийн дүн, төлбөр хүлээн авах банк, дансны мэдээлэл, шинжилгээний хариу бэлэн болох хугацааг экспортлогч аж ахуйн нэгжийн төлөөлөгчид мэдэгдэнэ

Экспортлогч аж ахуйн нэгжийн ажилтан УМЭАЦЭЛ-ын шинжилгээний дүгнэлт авахдаа шинжилгээний төлбөр төлсөн баримтаа лабораторын хүлээн авахын эмчид өгнө.

Экспортлогч аж ахуйн нэгжийн ажилтан УМЭАЦЭЛ-ын шинжилгээний дүгнэлтийг МХЕГ-ын томилсон байцаагчид өгөх ба байцаагч шинжилгээний дүгнэлтийг үндэслэн тухайн аж ахуйн нэгжид “Мал эмнэлгийн гэрчилгээ” олгоно. Дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох тохиолдолд “Мал эмнэлгийн гэрчилгээ” (Форма №26) сертификат олгоно.

4.1.2. ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТОЛЖ ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ ГЭРЧИЛГЭЭ (ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ)

Экспортлогч аж ахуйн нэгж “Мал эмнэлгийн гэрчилгээ” авсан тохиолдолд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас экспортын бүтээгдэхүүний “Гарал үүслийн гэрчилгээ” авах хүсэлтийг <https://www.mongolchamber.mn/p/22> холбоосоор онлайн хэлбэрээр илгээнэ. Гарал үүслийн гэрчилгээ FORM A авахыг хүссэн бизнес эрхлэгчид доорх бичиг баримтуудыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Худалдах, худалдан авах гэрээний хуулбар
- Өргөдөл (Form B)
- Үнийн нэхэмжлэх, орос эсвэл англи хэлээр
- Сав баглаа боодлын жагсаалт эсвэл англи орос хэлээр
- Аж ахуйн нэгжийн хүчин төгөлдөр бүхий улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

- Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл болон чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар гэх мэт.

Бэлэн болсон гэрчилгээ авахдаа МҮХАҮТ-ын дансанд гэрчилгээний төлбөр хийсэн баримтыг гэрчилгээ олгох ажилтанд өгнө. МҮХАҮТ гарал үүслийн гэрчилгээний эх хувийг хоёр хувь хуулбарын хамт экспортлогч аж ахуйн нэгжид олгоно. Гарал үүслийн гэрчилгээн дээрхи танхимын тамга, гарын үсэг тод томруун гаргацтай өөрөөр хэлбэл зөрчилгүй байх ёстой. *Гарал үүслийн эрчилгээ ямар нэг доголдолтой бол ОХУ-ын импортлогч тал импортын татварын 25%-ийн хөнгөлөлт, энэ хөнгөлөлтийн дүнд ногдох НӨАТ-ын илүү төлөтийг буцаан авч чадахгүй.*

Экспортлогч аж ахуйн нэгж “Мал эмнэлгийн гэрчилгээ”, “Гарал үүслийн гэрчилгээ”-г хамтад нь Стандарт хэмжил зүйн төвд авч очин “Тохирлын гэрчилгээ” авна.

4.1.3. ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Стандарт, Хэмжил Зүйн Газраас экспортлогч нь тохирлын гэрчилгээ авах ба энэхүү гэрчилгээ нь экспортод гаргах бүтээгдэхүүн нь холбогдох стандартуудын дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна.

4.1.4. ГАРАЛ ҮҮСЛИЙН УЛ МӨРИЙГ МӨШГИХ (TRACEABILITY)

Монгол Улсад амьд мал болон малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн системийг хөгжүүлэн дотоодын мал эмнэлэгийн гэрчилгээний цахим системийг нэвтрүүлэх төсөл хэрэгжиж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл-шилжилт хөдөлгөөн, эрүүл байдлыг хянах тогтолцоо бий болж байгаа нь малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болж байна. Энэхүү тогтолцоонд дараах мэдээллийг агуулдаг. Үүнд:

- Тухайн малыг маллаж байсан малчны талаарх мэдээлэл (гарал үүслийг тогтооход анхдагч мэдээлэл)
- Мал эмнэлгийн гэрчилгээнд тухайн малын бэлчээрлэдэг нутгийн талаарх мэдээлэл
- Борлуулалтын гэрээ хийгдсэн бүх малыг дахин давтагдахгүй дугаартай Radio Frequency Identificaiton (RFID) ээмэг зүүж, мал эмнэлгийн гэрчилгээг хөтлөхдөө дээрх малчин болон бэлчээрийн мэдээллүүдээс гадна мал, малын гаралтай бүтээгдэхүүний мэдээлэл

Дээрх мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн гар дээр гарал үүсэл, эрүүл байдал нь баталгаажсан малын махыг хүргэх боломжтой болж байна.

4.2. ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

Экспортлогч аж ахуйн нэгж дээр дурьдсан гурван гэрчилгээг авсны дараа Улаанбаатар хотын гаальд экспортын барааны ачилтад хяналт тавих байцаагч томилуулах тухай хүсэлт гаргана.

Экспортлогч аж ахуйн нэгж гаалийн хяналтын байцаагч томилуулах тухай хүсэлттэй нэгэн зэрэг гаалийн мэдүүлэгчээр “Улсын хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг”-ийн бүрдүүлэлтийг хийлгэнэ. (Гаалийн мэдүүлэгчид өгөх бичиг баримт: Экспортлогч аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, Гарал үүслийн гэрчилгээ, Тохирлын гэрчилгээ, Гадаад худалдааны гэрээ, Төлбөрийн нэхэмжлэл/Invoice,

сав баглаа боодлын цуваа/Packing list, Олон улсын ачаа тээврийн падаан/CMR, Тээвэрлэгч байгууллагатай хийсэн гэрээ болон Талуудын хооронд тохиролцсон бусад бичиг баримтыг тохирсон тоо хэмжээ ёсоор бүрдүүлнэ).

Гаалийн бүрдүүлэлт гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагаа юм.

Экспортын гаалийн бүрдүүлэлт дараах үе шаттай явагдана:

1. Мэдүүлэх
2. Гаалийн бичиг баримтыг шалгах
3. Бараа, тээврийн хэрэгслийг шалгах
4. Гаалийн болон бусад татварыг ногдуулж, шаардлагатай тохиолдолд барагдуулах
5. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх.

“Мэдүүлэх” гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаархи шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын²⁹ дагуу бичиж, холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгөхийг ойлгоно.

5. БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ АЖ АХУЙН НЭГЖИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

5.1. ЗАХ ЗЭЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР

1. Гадаад зах зээлийн сегментээ зөв тодорхойлох, үүнд: (¹Алс дорнодын загас агнуурын компани, ²Газрын тос, байгалийн хий олборлох компани, ³Уул уурхай, зам барилгын компани, ⁴ОХУ-ын Холбооны (Федеральный) хэмжээний гипермаркетууд, ⁵Мах ховор Сибирь, Урал, Якут зэрэг бүс нутаг, ⁶Хүн ам ихтэй хотууд Москва 12.5 сая, Санкт-Петербург 5.3 сая, Урал, Сибирийн Новосибирск, Екатеринбург, Челябинкс, Омск, Красноярск, Пермь зэрэг ОХУ-д 1 саяас дээш хүн амтай 15 хот байна. Эдгээр хотуудын хүн ам нийлээд 32-35 сая болдог байна.

2. Холбооны хэмжээний гипермаркетууд (Пятерочка, Перекресток, Дикси, Магнит, Ашан) бүгд дунджаас доогуур хямд үнийн, түргэн эргэлттэй хүнсний бараа зардаг тул эдгээр сүлжээнд нийлүүлэх консерв хямд үнэтэй байх шаардлагатай. Иймд эдгээр сүлжээний аль нэгтэй ажиллах тохиолдолд бүтээгдэхүүний сонголт чухал, өөрөөр хэлбэл өөрийн өртөг багатай бүтээгдэхүүнийг маш олон тоогоор үйлдвэрлэнэ гэсэн үг. Нэг л гиперсүлжээний дэлгүүрийн тоо 10000, түүнээс дээш тул худалдан авалт маш өндөр байдаг. (борлох магадлалтай бүтээгдэхүүн: 50-100 граммаар савласан хатаасан мах, мах болон элэгний нухаш, зүрх, дотор махаар хийсэн нухаш, консерв, будаа, бэлэн гоймонтой холих бага порцоор савласан жигнэсэн болон хатаасан мах, дээрхи гипермаркетуудтай харилцан

²⁹ <http://customs.gov.mn/images/samenu/meduuleg.jpg>

тохирсон жороор хямд үнэтэй бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэж болох талтай). Гиперсупермаркетийн борлуулалтын философи нь “хурдан хэрэглэгдэх өргөн хэрэглээний бараа” (Fast Moving Consumer Goods-FMCG), өөрөөр хэлбэл өдөр тутмын хэрэглээний бараа гэсэн үг. Ийм учир энэ дэлгүүрүүдийн салбар гэрийн ойролцоо, орон сууцны хорооллуудад ихээр байгуулагдсан ба байнгын үйлчлүүлэгчидтэй, борлуулалт сайтай байдаг. Энэ нь “нүдээ” олсон бүтээгдэхүүн олж үйлдвэрлэж чадвал борлуулалтанд санаа зовохгүй гэсэн үг.

3. Худалдан авагч түншээ хайхдаа МҮХАҮТ, ОХУ-ын болон гаалийн холбооны гишүүн орнуудад байгаа манай улсын Элчин сайдын яам, Консулын газар, Худалдааны төлөөлөгчийн газар зэрэг байгууллагын дэмжлэг тусламжийг авч болох юм. Мөн манай оронд дээрхи улсуудыг төлөөлж байгаа Элчин сайдын яам, Консулын газар, Худалдааны төлөөлөгчийн газар зэрэг байгууллагаар дамжуулан түнш хайж болох юм.

4. Нүүдлийн соёлтой манай улстай сайн харилцаатай Казахстан, Киргизстан, ОХУ-ын мужууд болох Татарстан, Тува, Халимаг зэрэг орнуудын зах зээлд адуу, хонь, ямааны **халал** махан консерв болон дотор махаар хийсэн бүтээгдэхүүн борлуулагдах магадлал өндөртэй. ОХУ-д мусульман шашинтай хэрэглэгчид 20,0 гаруй сая хүн байгаа бөгөөд энэ хүмүүсийн төлөөлөл **халал** махаар хийсэн жигнэсэн мах ховор байдаг тухай гомдол тавьж байсан тухай мэдээлэл бий. Москва хотод жил бүр **халал** бүтээгдэхүүний үзэсгэлэн зохиогддог болохыг энд цухас дурдъя.

5. Экспортлох бүтээгдэхүүний сонголтоо зөв хийх (үхэр, хонь, адуу, хонины махан консерв, хатаасан мах болон будаа, бор будаа, гурвалжин будаатай махан консерв (мясорастительные консервы), элэгний нухаш, махан нухаш, доор махан нухаш, таван цулын шөл, дотор махан консерв, (зүрх+уушиг+гүзээ+бөөр+элэг) гэх мэт бүтээгдэхүүн байж болох юм.

6. Бүтээгдэхүүний савлагааны төрөл, жингийн хэмжээг зөв сонгох : лааз, шилэн сав, полимер уут, жин 338 грамм, 500 грамм, 1,0 кг, 3 кг, 5 кг гэх мэт)

7. Оросын хэрэглэгчдийн таашаалд нийцсэн амт чанартай консерв хийхийн тулд технологийн хувьд оросын жорыг авах нь зүйтэй, харин манайхтай төстэй нүүдлийн соёлтой орнуудад дотор мах, борц, таван цулын шөл гэх мэт бүтээгдэхүүн экспортлох гэж байгаа бол манай эсвэл дээрхи орнуудын үндэсний жор байж болох юм.

8. Бүтээгдэхүүний сав баглаа боодлын дизайн чухал. Оросын болон бусад зах зээлийн хэрэглэгчдийн таашаалд нийцэхээр байх хэрэгтэй. Мусульман шашинтай Казахстан, Киргизстан, ОХУ-ын муж болох Татарстан зэрэг орнуудын зах зээлд ихэвчлэн ногоон, хар өнгө бүхий шошготой савлагаа зонхилох ба бүтээгдэхүүний савлагааны хэмжээ бас л бодох зүйл. Оросын худалдан авагчид 338 грамmd дассан байдаг боловч хэрэглэгчийн хүсэлтээр савлагааны жин 1-5 кг байж болох юм. Гэхдээ оросын жигнэсэн махны стандартад (ГОСТ) савлагаа тус бүрийн төрлөөс хамаарч түүнд савлаж болох бүтээгдэхүүний дээд хэмжээг заасан байдаг тул үүнийг анхааралдаа бас авах хэрэгтэй.

9. Бүтээгдэхүүний зар сурталчилгаа маш чухал тул захиалагчтайгаа хамтран зах зээлийн сегменттэйгээ уялдуулан оновчтой хийх хэрэгтэй.

5.2. ОХУ-ЫН ГААЛЬ ДЭЭР ГАРДАГ ЗАРИМ АСУУДАЛ БУСАД ЗҮЙЛИЙН ТАЛААР

Экспортын барааг поддон/тавиур дээр ачихад оросын гааль поддоны гаалийн бүрдүүлэлт хийхийг шаарддаг тул импортлогчийн зүгээс гаалийн мэдүүлэгчид төлөх бүрдүүлэлтийн нэмэлт зардал гарахаас гадна (оросын гаалийн бүрдүүлэгчид ажлын хөлсийг гаалийн бүрдүүлэлт хийсэн барааны тоогоор тооцдог, жишээ нь нэг төрлийн барааны бүрдүүлэлт хийхэд 10000 рубль гэх мэт) поддоны ургамал хорио цээрийн гэрчилгээ, поддоныг буцаах эсэх, түүний үнэ хэд болох зэрэг асуудал үүсдэгийг анхаарах хэрэгтэй. Барааг заавал поддон дээр ачих бол түүний импортын бүрдүүлэлтэнд ямар ямар бичиг баримт хэрэгтэй болохыг худалдан авагч талаас урьдчилан асуух нь зүйтэй.

Зарим тохиолдолд оросын талын гаалийн мэдүүлэгч монголын гаалийн мэдүүлгийн хуулбарыг орчуулгын хамт түүнд ирүүлэх хүсэлт тавьдаг. Энэ нь түүний зүгээс гаалийн мэдүүлэгт заасан барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, тээврийн хэрэгслийн тухай мэдээлэл зэрэг нь үнэн гэдгийг монголын талын гаалийн мэдүүлгээр баталж байгаа хэрэг болно. Өөрөөр хэлбэл хил дээр барааг саатуулах эрсдэлийг багасгаж байгаа хэрэг юм.

Оросын хил дээр барааг гаалийн нэмэлт үзлэгт (таможенный досмотр) оруулах нөхцөл бас үүсдэг. Энэ тохиолдолд оросын гаалийн ажилтнууд болон хилийн мал эмнэлэг, хорио цээрийн байцаагчид барааг тээврийн хэрэгслээс буулгаж нэгж бүтээгдэхүүний жин, тээврийн нэгж сав баглаа боодлын жин, барааг савласан хайрцагны жин зэргийг шалгаж тээврийн падаан, сав баглаа боодлын хуудсанд (упаковочный лист) бичигдсэн барааны тоо хэмжээ, цэвэр, бохир жинг шалгахаас гадна бараанаас шинжилгээнд зориулан дээж авдаг. Гаалийн нэмэлт үзлэг дууссаны дараа оросын гааль нэмэлт үзлэг хийсэн тухай акт үйлдэж импортлогчийн төлөөлөгчөөр гарын үсэг зуруулна. Барааг бүгдийг нь буулгаж тоолуулахаас зайлсхийх нэг арга бол экспортлогч тал нь барааг ачихдаа, ачсан барааны дундуур хүн явж болох зай үлдээх хэрэгтэй. Энэ тохиолдолд оросын гаалийн байцаагч барааны дундуур явж барааг тоолох боломжтой болох бөгөөд бүх барааг буулгах шаардлага үгүй болно.

Мөн шаардлагатай гэж үзвэл оросын гаалийн алба, гаалийн үнэ (таможенная стоимость) бүрдэлтийн тухай нэмэлт шалгалт явуулах шийдвэр гаргадаг. (Решение о проведении дополнительной проверки для таможенной стоимости.) Энэ тохиолдолд импортлогч тал оросын гаалийн тооцсон жишиг үнээр гааль болон НӨАТ-ыг төлж байж гаалийн түр горимоор бараагаа авна. Дараа нь экспортлогч, импортлогч талууд үнээ батлах талаар хамтран ажиллаж гаалийн байгууллагаас тавьсан асуултуудад хариулсан тайлан бичих хэрэгтэй болдог. Тайланг гаалийн байгууллагын заасан хугацаанд бүрдүүлж талуудын гэрээнд заасан үнэ, ачаа тээврийн гэрээнд заасан тээврийн зардал үнэн зөв гэдгийн нотлохгүй бол гаалийн үнийг жишиг үнээр тооцож нэмж төлсөн татварыг буцааж олгохгүй. Тайлангаа хамгаалж чадвал импортлогч тал нэмж төлсөн татвараа буцааж авна. Гаалийн үнээ хамгаалан тайлан бичих хугацааг гааль тодорхойлох ба энэ нь ойролцоогоор 30 хоног байдаг.

Экспортлогчийн төлбөр хүлээн авах банк нь импортлогчийн банктэй шууд харилцаатай (дундын банк байхгүй гэсэн үг) бол төлбөр тооцоо хурдан орж ирнэ. Тухайлбал манай ихэнх банкууд ОХУ-ын Сбербанктэй шууд харилцдаг. Гадаад төлбөр тооцоо хүлээн авах банкны

мэдээллийг харилцагч банкнаасаа албан ёсоор авах нь зүйтэй. Сбербанкаар хийсэн гадаад гүйлгээ 1-2 хоногт таны дансанд орно.

Хадгалах болон тээвэрлэх явцад **чанараа** ямар нэг хэмжээгээр алдаж, эрүүл ахуйн аюултай байдал үүсэж болзошгүй тул тээврийн сав баглааны даацыг сайтар тооцох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нэг хайрцагт хэдэн консерв хийх, консервтей хайрцагаа хэдэн давхар өрж болох вэ гэдгээ тооцож байж тээврийн сав баглаагаа (хайрцагаа) захиалах хэрэгтэй. Оросын картон хайрцаг үнэ боломжийн, бөх бат байдаг бөгөөд хайрцагаа гаалийн түр горимоор оруулж ирээд буцааж орос руу гаргаад НӨАТ-аа буцаан авч болно.

Экспортын үйл ажиллагаанд гарч болох эрсдэлүүд (төлбөр, даатгал, тээвэрлэлт, хорио цээр г.м) болон тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, шийдвэрлэх арга замын асуудлыг аль болох урьдчилан тооцох хэрэгтэй.

Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг экспортлогч компани шалгах хэрэгтэй. Учир нь ОХУ-ын хил дээр тээврийн хэрэгслийн арлын дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээнд бичсэн дугаар хоёр хоорондоо зөрж байсныг оросын гаалийн ажилтан илрүүлж байсан удаа бий. Мөн жолооч, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхээ мартаж, өөр хүний жолооны үнэмлэх авч явж байсан ч тохиолдол гарч байсан.

Эцэст нь гадаад түнштэйгээ урт удаан хугацаанд найдвартай **хамтын ажиллагаа** тогтоож үйлдвэрлэл болон экспортын явцад гарч болох форс мажор болон бусад асуудлыг хамтдаа, найдвартай түншийн хэмжээнд шийдвэрлэж харилцан итгэлцэл бий болгох нь чухал гэдгийг тэмдэглэе.

6. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

6.1. МОНГОЛЫН ТАЛААС БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн нэр	Олгох байгууллага	Тайлбар
1	Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн экспортлох квот	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Экспортлогч аж ахуйн нэгжид бүтээгдэхүүн экспортлох квот олгоно. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, Мал эмнэлгийн гэрчилгээ олгох тухай албан бичиг олгоно.
2	Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ	Мал эмнэлгийн ерөнхий газар	“Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” олгоно. Экспортлогч ОХУ-аас өөр улсад мах, махан бүтээгдэхүүн гаргах бол Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын албанд (Россельхознадзор) энэ тухай албан тоот илгээнэ.
3	Мал эмнэлгийн гэрчилгээ Форма № 26	МХЕГ-ын Экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын газар	Экспортын бүтээгдэхүүнд “Мал эмнэлгийн гэрчилгээ” (Форма № 26) олгож, экспортын ачилтын гаалийн бүрдүүлэлт дуусах үед энэ гэрээнд тамга дарна, гарын үсэг зурна, хилийн боомт дахь хяналтын албанд “Экспортын мэдэгдэл” бичнэ.

4	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг	Гаалийн ерөнхий газар	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг барааны дагалдах баримт бичгийн хамт баталгаажуулна
5	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газар	Бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгоно.
6	Бүтээгдэхүүний дээжинд мал эмнэлэг ариун цэврийн шалгуур үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж дүгнэлт гаргана.	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори	Шинжилгээний дүгнэлтийг үндэслэн МХЕГ экспортын бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн гэрчилгээ олгох, эс олгох асуудлыг шийдвэрлэнэ
7	Бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ (FORM A) олгоно.	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Гарал үүслийн гэрчилгээ нь импортлогч талын хувьд гаалийн татвараас 25%-ийн хөнгөлөлт эдлэх үндсэн баримт болно
8	Олон улсын ачаа тээврийн падаан СМР	Тээвэрлэгч байгууллага	Олон улсын ачаа тээврийн падаан нь улс хоорондын тээвэр хийх үндсэн баримт болно
9	Төлбөрийн нэхэмжлэл, сав баглаа боодлын цуваа	Экспортлогч аж ахуйн нэгж	
10	Гадаад худалдааны гэрээнд заасан бусад бичиг баримт	Экспортлогч аж ахуйн нэгж	

6.2. ОХУ-ЫН ТАЛААС ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА, БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

№	Баримт бичгийн нэр	Олгох байгууллага	Тайлбар
1	Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний импортын зөвшөөрөл (Разрешение на ввоз)	Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын алба (Россельхознадзор)-наас олгоно)	Энэ зөвшөөрлийг импортлогч тал өөрийн орон нутаг дахь хөдөө аж ахуйн хяналтын албанаас авч экспортлогч талд илгээнэ. Энэхүү зөвшөөрлийг аваагүй тохиолдолд барааг ОХУ-ын хилээр нэвтрүүлэхгүй.
2	Тохирлын гэрчилгээ (Декларация о соответствии)	Оросын холбооны улсын тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас олгоно	Оросын холбооны улсын тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас дулааны аргаар боловсруулсан бөгөөд импортлох бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрт 1-3 жилийн хугацаагаар олгоно. Энэ гэрчилгээ байхгүй бол тухайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээлд борлуулж болохгүй
3	Автомашинаар бараа тээвэрлэх урьдчилсан мэдээлэл /Предварительная информация для перевозок автотранспортом	Бараа импортлох үед хилийн боомт дахь холбооны гаалийн албанаас олгоно.	Импортлогч энэ мэдээллийг авсны тээвэрлэгчид мэдэгдэх ба үүний дараа тээврийн хэрэгсэл ОХУ-ын хилийн боомт руу орох эртэй болно. Тээвэрлэгч нь энэ мэдэгдлийг цаасаар аваагүй мэдэгдлийн дугаарыг импортлогч талаас авч хилийн шалганы ажилтанд хэлж болно.
4	Гаалийн мэдүүлэг	Холбооны гаалийн алба (Федеральная таможенная служба),	Тухайн экспортын ачилттай холбоотой бүх мэдээлэл болон бичиг баримтуудыг ОХУ-ын гаалийн цахим мэдээллийн санд урьдчилан 3-5 хоногийн өмнө мэдүүлж, бэлтгэл ажлыг хийх

7. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ОРОЛЦДОГ БАЙГУУЛЛАГА


№	Байгууллагын нэр	Холбоо тогтоох хаяг, мэйл, утас
I. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА		
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Монгол улс, Улаанбаатар хот 13381 Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр. И-мэйл: mofa@mofa.gov.mn Вэб: mofa.gov.mn Утас:51-262271 Факс: 51-263237	
Мал эмнэлгийн ерөнхий газар	Монгол улс, Улаанбаатар хот, 13381 Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр. И-мэйл: info@dvab.gov.mn Вэб: https://zasag.mn/m/avab	
МХЕГ-ын Экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын газар	Монгол улс, Улаанбаатар хот 15170, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-13, Засгийн газрын XII байр. И-мэйл: info@inspection.gov.mn Вэб: www.inspection.gov.mn Утас: (+51) 264786, 263790	
Гаалийн ерөнхий газар	Монгол улс, Улаанбаатар хот, 14193, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 81/1 байр. И-мэйл: info@customs.gov.mn Вэб: http://customs.gov.mn/ Шууд утас: 1800-1281, 11350049 Факс: (976-11) 350048	
Стандарт хэмжил зүйн газар	Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино-Хайрхан дүүрэг, 18-р хороо Стандарт, хэмжил зүйн газрын 2-р байр , Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалт Утас: 70185289, 70185427 И-мэйл: Вэб: https://masm.gov.mn/masmj/ Утас: 70185289, 70185427	
Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Хан-Уул дүүрэг, ШХ-53/03, Утас: 70111050 +97670111050	
Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Монгол улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг,15-р хороо, Махатма Гандигийн гудамж Хэрэглэгч, Үйлчилгээний Газар Утас: (976) 77277070-3 Е-мэйл: export@mongolchamber.mn Вэб: https://www.mongolchamber.mn/p/60	
II. НИЙЛҮҮЛЭГЧИД		
Дулааны аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн өөрийн мал төхөөрөх цех	Үхрийн мах нийлүүлнэ	
ОХУ-д үхрийн гулууз мах экспорлох эрх бүхий компаниуд (Стандартын шаардлага хангасан, мал эмнэлгийн дагалдах бичиг баримттай үхрийн мах)	Оросын холбооны улсын хөдөө аж ахуйн хяналтын алба, Россельхознадзор-ын вэб сайтад бүртгэлтэй монголын мал төхөөрөх (үхэр) аж ахуйн нэгжүүд. https://www.fsvps.ru/fsvps/importExport/mongolia/enterprises.html?product=1&productType=1	
Дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэгдэх,	Дулааны аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн гадаад, дотоод түншүүд.	

стандартын шаардлага хангасан туслах түүхий эд болох давс, сонгино, хар перец, лаврын навч бусад түүхий эд (цагаан будаа, гурвалжин будаа, хөц будаа) нийлүүлэх гадаад дотоодын компани	
Бүтээгдэхүүн савлах лааз, шилэн сав, нийлэг уут зэрэг сав, баглаа боодол болон тээвэрлэлтийн хайрцаг нийлүүлэх гадаад дотоодын компани	Дулааны аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн гадаад, дотоод түншүүд.
III. ХЭРЭГЛЭГЧИД	
Дотоодын зах зээл	Томоохон супермаркет, хүнсний дэлгүүр
ОХУ-ын зах зээл	Импортлогч аж ахуйн нэгжүүд
Евразийн эдийн засгийн холбооны орнуудын зах зээл	Импортлогч аж ахуйн нэгжүүд
IV. ЛОГИСТИК	
Улс хоорондын тээвэр хийх эрх бүхий тээвэрлэгч аж ахуйн нэгж	Монголын Тээвэр Жуучлагддын Нэгдсэн холбооны гишүүн аж ахуйн нэгжүүд Байршил : БГД, ДЭМ оффис, 213 тоот Утас : 94004282 Имэйл : office@forwarders.mn вэб: http://forwarders.mn

8. ОХУ-Д БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ПРОГНОЗ

ОХУ-д экспортлох боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох прогнозыг хийхдээ Монгол Улсын бэлчээрийн даацад тохирох үхрийн тоо, мал сүргийн бүтэц, дотоодын хэрэглээ, мах бэлтгэл зэрэгт үндэслэсэн болно.

Зураг 8. ОХУ-д экспортлох боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний прогноз



Эх сурвалж: Пүрэв Б., Отгонсайхан Н., Мөнхбаясгалан Г. “Монгол Улсын махны экспортыг тогтвортой хөгжүүлэх боломж” илтгэл, “Худалдаа ба тогтвортой хөгжил” ОУЭШХ, 2019.10.11

Монгол Улс бэлчээрийн даацад тохирсон, сүргийн оновчтой бүтцийг хадгалсан үхрийг өсгөж, хэрэглээнд зарлагадана гэж үзвэл жилд дундажаар 146756 тонн үхрийн мах бэлтгэх боломж байна. Үхрийн махны экспортын нийлүүлэлтийн функцээс харахад, экспорт зах зээлийн эрэлтээс ихээхэн шалтгаалахаар байгаа бөгөөд эрэлт 1 хувиар өсөхөд экспорт 7 нэгжээр нэмэгдэх боломжтой байна.

9. ХАВСРАЛТУУД

Хавсралт №1 Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах барааны нэгдсэн жагсаалт. */Единый перечень товаров, подлежащих ветеринарному контролю/*
https://www.fsvps.ru/fsvps-docs/ru/laws/tsouz/vet_list.pdf

Хавсралт №2 Гаалийн холбооны орнуудын гаалийн хил болон гаалийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн журам */Положение о едином порядке осуществления ветеринарного контроля на таможенной границе таможенного союза и на таможенной территории таможенного союза/*
https://www.fsvps.ru/fsvps-docs/ru/laws/tsouz/tsouz_vetcontrol.pdf

Хавсралт №3 Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах объектыг хамтран шалгах болон барааны дээж авах тухай нэгдсэн журам */Положение о едином порядке проведения совместных проверок объектов и отбора проб товаров подлежащих ветеринарному контролю/*
<http://www.fsvps.ru/fsvps/laws/4738.html>

Хавсралт №4 Мал эмнэлгийн хяналтанд хамрагдах бараанд тавигдах мал эмнэлэг ариун цэврийн нэгдсэн шаардлага */Единые ветеринарно-санитарные требования, предъявляемые к товарам, подлежащим ветеринарному контролю/*
https://www.fsvps.ru/fsvps-docs/ru/laws/tsouz/tsouz_vettreb.pdf

Хавсралт №5 Мал эмнэлгийн сертификатын нэгдсэн хүснэгт */Единые формы ветеринарных сертификатов/*
http://fsvps.ru/fsvps-docs/ru/laws/tsouz/tsouz_form.pdf

Хавсралт №6 Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас

Хавсралт №7 Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн шаардлагыг шалгах хяналтын хуудас

Хавсралт №8 Мах эхлэн боловсруулах үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас

Хавсралт №9 Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас

Хавсралт №10 Махны хадгалалтын нөхцөлийг шалгах хяналтын хуудас

Хавсралт №11 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас

Хавсралт №12 Тохирлын гэрчилгээ / Certificate of conformity (Стандарт хэмжилзүйн төв)

Хавсралт №13 Гарал үүслийн гэрчилгээний загвар FORM A (МҮХАҮТ)

Хавсралт №14 Гарал үүслийн гэрчилгээ авах тухай өргөдлийн загвар FORM B (МҮХАҮТ)

Хавсралт №15 Үнийн нэхэмжлэл, сав баглаа боодлын жагсаалт орос хэлээр (МҮХАҮТ)

Хавсралт №16 Үнийн нэхэмжлэл, сав баглаа боодлын жагсаалт англи хэлээр (МҮХАҮТ)

Хавсралт №17 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас (МХЕГ)

Хавсралт №18 Экспортын гэрчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт (МХЕГ)

Хавсралт №19 Сав баглаа боодлын аюулгүй байдлын тухай техникийн зохицуулалт
ТР ТС 005/2011 орос хэлээр

<http://www.eurasiancommission.org/ru/act/txnreg/deptexreg/tr/Documents/TR%20TS%20Upakovka.pdf>

Хавсралт №20 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай техникийн зохицуулалт
ТР ТС 021/2011 орос хэлээр

<http://www.eurasiancommission.org/ru/act/txnreg/deptexreg/tr/Documents/TR%20TS%20PishevayaProd.pdf>

Хавсралт №21 Хүнсний бүтээгдэхүүний шошгололтын тухай техникийн зохицуулалт
ТР ТС 022/2011 орос хэлээр

<http://www.eurasiancommission.org/ru/act/txnreg/deptexreg/tr/Documents/TrTsPishevkaMarkirovka.pdf>

Хавсралт №22 Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай техникийн зохицуулалт
ТР ТС 034/2013 орос хэлээр

https://docs.eaeunion.org/docs/ru-ru/0043629/cncd_11102013_68

Хавсралт №23 ГОСТ Р 54033-2010 Консервы мясные. Мясо тушеное. Технические условия

<http://docs.cntd.ru/document/1200084353>

Хавсралт №24 ГОСТ 30425-97 Метод определения промышленной стерильности

<http://docs.cntd.ru/document/1200022909>

Хавсралт №25 Положение о едином порядке проведения совместных проверок объектов и отбора проб товаров, подлежащих ветеринарному контролю

<http://docs.cntd.ru/document/420226104>

Хавсралт №26 Положение о едином знаке обращения продукции на рынке государств - Членов Таможенного союза

<http://docs.cntd.ru/document/902293429>

Хавсралт №27 Изображение единого знака обращения продукции на рынке Евразийского экономического союза

<http://docs.cntd.ru/document/902293429>

Хавсралт №28 Дулааны аргаар боловсруулсан үхрийн махан нөөшинд олгох мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Форма № 26)

Хавсралт №29 Адууны хөлдүү маханд олгох мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ 25 цэврийн гэрчилгээ (Форма №25)

Хавсралт №30 Импортын зөвшөөрлийн загвар/ разрешение на ввоз

Хавсралт №31 Декларация о соответствии

Хавсралт №32 Олон улсын ачаа тээврийн падаан (CMR)

Хавсралт №33 Экспортлогч байгууллагын дотоод үйл ажиллагаандаа ашиглах шалгах хуудас

Хавсралт №34 Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн дотоод хяналтын журмын загвар

Хавсралт №35 Хүнсний үйлдвэрт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм

Хавсралт №36 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам

Хавсралт №37 Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтлийн үйл ажиллагаанд мөрдөх
эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм

Хавсралт №38 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хүүхдийн байгууллагын ажилтанд тавих
эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журам